



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>9-33</i>

1.Цөмийн энергийн тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

9-33

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 10 дугаар
сарын 30-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 32 минутад Төрийн ордны “Жанжисин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Бат-Амгалан, Н.Наранбаатар, Ө.Шижир;
Чөлөөтэй: Х.Тэмүүжин, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, мөн газрын дэд дарга Д.Цолмон, Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Саруул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, мөн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Г.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга З.Баярхүү, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга Ж.Мөнх-Оргил, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн мэргэжлийн шинжээч, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, Захиргааны удирдлагын албаны дарга Д.Сугарсүрэн, Геологи, уул уурхайн албаны ахлах инженер А.Алтанхундага, мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр, Г.Жамсрандорж, Я.Ганболд, Д.Баярхүү нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад

бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Батбаатар, Ч.Анар, Н.Алтаншагай, М.Батсүмбэрэл, Д.Ганбат, Н.Номтойбаяр, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, мөн газрын дэд дарга Д.Цолмон, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Г.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга З.Баярхүү, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн мэргэжлийн шинжээч, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр, Г.Жамсрандорж, Д.Баярхүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Батбаатар, Ч.Анар, Д.Ганбат, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: 1.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Г.Тэмүүлэн: 2.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5

Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 51 минут үргэлжилж, 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин
Д.Сүхбаатар” танхим 13 цаг 32 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны **Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Та бүхэндээ Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтанишагай гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Батын Батбаатар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дашидондогийн Ганбат гишүүн, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн, Хажикбэрийн Жангабыл гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Пүрэвжавын Сайнзориг гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Лутаагийн Энхнасан гэсэн гишүүд хүрэлцэн ирсэн байна. Ингээд Байнгын хорооны ирц бүрдсэн тул Байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдөр хэлэлцэх асуудал нэг асуудал байгаа. Хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Цөмийн энергийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөл болон бусад хуулийн төслүүд Засгийн газар 10 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалд орохоос өмнө бас танилцуулга хийх сайд маань бас өөр

газар танилцуулга хийж байгаа. Одоо 13 цаг 34 минут болж байна. 15 цаг хүртэл байнгын хорооны хурлыг бол хуулийн төслийн танилцуулга хийх Учрал сайдыг иртэл хойшлуулж байна. Холбогдох албан тушаалтнууд орж ирэх хүртэлх хугацаанд буюу 3 цаг хүртэл хуралдааныг түр хойшлуулав.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны хуралдааныг үргэлжлүүлэе.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал нэг асуудал байгаа.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүд Засгийн газар 2024 оны 10 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудал байгаа. Ирцийн мэдээг би бас түрүүн танилцуулсан. Ингээд хэлэлцэх асуудалдаа бүгдээрээ орцгооё.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хүрэлцэн ирсэн албан тушаалтнуудыг хурлын танхимд оруулаарай. Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал сайд танилцуулна аа. Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Францын ураны төслийн хөрөнгө оруулалтын гэрээг өнгөрсөн хугацаанд Засгийн газар дээр ажлын хэсэг байгуулж ажилласан. Ингээд өнөөдөр байнгын хороонд Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл түүнийг дагалдан гарах холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах хуулийн төслийг танилцуулж байна аа.

Г.Тэмүүлэн: Түр хүлээж байгаарай Учрал сайд аа. Одоохон би 2, 3 минутад багтаагаад оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулаадахъя. Тэр болтол манай гишүүд нэмж орж ирж байг.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хүрэлцэн ирсэн оролцож байгаа албан тушаалтнуудыг та бүхэнд танилцуулж байя.

Эхлээд ажлын хэсгийн гишүүд Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нармандахын Жамъянхүү Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр Эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Ганбаатар байна уу? Гүнчинсүрэнгийн Намжилсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник технологийн хэлтсийн дарга. Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Зандангийн Баярхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын дарга, Баатарын Мөнхтогтох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Зэнээмядарын Батбаяр Усны газрын дарга, Гунаажавын Манлайжав Цөмийн нарийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга байхгүй байна дуудаарай. Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил СЗХ-ны Хууль, эрх зүйн газрын дарга, Доржбалын Далайжаргал Мон-Атомын гүйцэтгэх захирал, Алтансайханы Алтанхундага Мон-Атом ХХК-ийн Геологи, уул уурхайн

албаны ахлах менежер, Норовбаярын Тэгшбаяр Мон-Атом компанийн мэргэжлийн шинжээч, Галсангийн Жамсрандорж Мон-Атомын мэргэжлийн шинжээч, Яндагийн Ганболд мөн тус компанийн мэргэжлийн шинжээчээр байна. Лхасүрэнгийн Жаргалсайхан тус компанийн мэргэжлийн шинжээч, ШУА-ийн Хими химийн технологийн хүрээлэнгийн захирал, Дашдоржийн Баярхүү тус компанийн мэргэжлийн шинжээч гэсэн байна, Дашдаваагийн Сугарсүрэн тус компанийн Захиргааны удирдлагын албаны дарга гэсэн байна.

Учрал сайд.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг танилцуулж байна аа. Тус хуулийн төслөөр дараах 4 асуудлыг хуульчилсан. Төрийн эзэмшлийн хувь хэмжээг эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан өөрөөр тогтоож болох үндэслэл мөн АМНАТ -ийн хувь хэмжээ, аюулгүй ажиллагаа, уурхайн хаалт, нөхөн сэргээлт, хаягдлын менежмент, хөрөнгө оруулалт, гэрээний хугацааг хуульчилж байгаа гэдгийг хэлье. Энд хуулийн төслийн үндэслэл бол хуулийн төслийн зүйл дээр 5 дугаар зүйл дээр стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр орлуулах бас бүтээгдэхүүн хуваах төрийн эзэмшлийн хувь хэмжээний төрлийг өөрчлөх төрөөс оруулсан болон оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсын эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан 5.2, 5.3-д заасан хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болохыг хуульчилж байна. Мөн Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд АМНАТ -өөр орлуулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоох үндэслэлүүдийг тусгаж өгсөн. Та бүхэн мэдэж байгаа

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт 6.2 дээр бол байгалийн баялгийн дийлэнхийг ард түмэн эзэмшинэ гэсэн энэ суурь зарчмыг хангуулах хүрээнд бид нар Үндэсний баялгийн сангийн хуулийг парламентаас батлан гаргасан. Тэгээд Үндэсний баялгийн сангийн хуулиар бол төрийн эзэмшлийн хувь хэмжээг өөрөөр орлуулж болох буюу үүнд ашигт малтмал нөөц нөөц ашигласны төлбөрөөр орлуулах бүтээгдэхүүн хуваахаар орлуулах мөн төрлийг өөрчлөх төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсын эдийн засагт үр ашигтай байх хувилбарыг харгалзан Засгийн газрын мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болох үндэслэлүүдийг тусгаж өгсөн гэдгийг хэлье ээ.

Ингээд энэ бол мэдээж дэлхий дахинд өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа эрчим хүчний салбарын шилжилттэй холбож бол тайлбарлаж болно. Дэлхий дахинд бол эрчим хүчний салбар солонгорч байна өөрчлөгдөж байна. Дээрээс нь манай улс бол хүлэмжийн хийг бууруулах амлалтыг бол өгсөн.

Үүнд бол 1994 оны Киотогийн протокол, 2015 оны Парисын хэлэлцээр, 2021 оны Глазковын хэлэлцээрийн дагуу бол бид 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлын 22.7 хувиар бууруулах амлалтыг бол өгсөн байдаг. Тэгэхээр Монгол Улс бол нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгаварлын хэмжээгээр бол дэлхийд одоогийн байдлаар бол 9-д жагсаж байгаа. Тэгэхээр дэлхийн ихэнх улс орнууд бол нүүрс төрөгчөөс татгалзаж байна. Тэгэхээр нүүрс төрөгчийн хий ялгаруулдаггүй тогтвортой ногоон эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бол дэлхийн улс орнууд бол эрэлхийлж байгаа.

Тийм ч учраас уран өөрөө уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чухал ач холбогдолтой байгалийн баялаг гэж бол үздэг. Үүнийг хүлэмжийн хийн ялгарлын талаар дэлхийн цөмийн нийгэмлэгийн гаргасан судалгаагаар

цөмийн эрчим хүч нүүрстэй харьцуулахад 68 дахин бага хүлэмжийн хий ялгаруулдаг гэсэн тооцоолол байдаг. Тэгэхээр өнөөдрийн одоо 100 мянган кг нүүрс бол 1кг цөмийн түлштэй тэнцдэг. Тэгэхээр Монгол Улс бол жилийнхээ хэрэглээнд 7.5 сая тонн нүүрс хэрэглэж байна гэдэг бол энэ өөрөө 75 тонн цөмийн түлшийг хэрэглэнэ л гэсэн ийм л үг.

Тийм учраас бол цөмийн эрчим хүч уран бол өөрөө эрчим хүчний хувь хувьд бол маш өд өндөр эрчим хүчийг ялгаруулдагараа бол онцлогтой. Энэ бол дэлхийн улс орнууд дээрээс тодорхой харагдаж байгаа. Жишээ нь зах зээлийн чиг хандлагын хувьд бол Монгол Улсын Цөмийн энергийн байгууллагаас гаргасан энэ судалгаагаар 2050 он хүртэл харахад бол тасралтгүй бол энэ ураны зах зээлийн эрэлт бол дандаа нэмэгдсэн ийм судалгаанууд гарсан. Тэгэхээр ураны нөөцтэй дэлхийн улс орнууд дотор манайх улс бол эхний 10-д явж байгаа.

Тэгэхээр эхний 10-д явж байна гэдэг бол өнөөдрийн зөвхөн тогтоогдсон нөөц цаашидаа бол энэ тоо бас урагшлах бололцоотой байгаа. Уран олборлолтоороо тэр тэргүүлэгч улс орнуудыг харьцуулаад үзэхэд бол 1990 оноос хойш адилхан. Бид нартай шилжилт хийсэн улсууд дотроос бол жишээ нь Казахстан улс бол энэ ураны олборлолтоороо 43.4 хувийг эзэлж байгаа. Дэлхийд 1 дүгээр байранд бол орсон байдаг. Тэгэхээр цөмийн эрчим хүч үйлдвэрлэж байгаа улсууд дээр бол нийт дэлхий нийтэд нэг өнөөдрийн байдлаар 440 реактор бол байдаг. Одоо бол нэг баригдаж байгаа бол нэг 63, барилгаа барихаар төлөвлөж байгаа 88, мөн ирээдүйд төлөвлөж байгаа 344 гээд реакторын тоо бол тасралтгүй өснө өө гэсэн ийм үзүүлэлт байгаа учраас бол бид энэ Монгол Францын хамтарсан ураны төслийг урагшлуулахын тулд Монголын талд ашигтай байх хэлбэрээр зохион байгуулахын тулд эхлээд хууль эрх зүйн орчноо өөрчлөх зайлшгүй шаардлага бол

бидний өмнө бол байна гэдэг нь харагдаж байгаа.

Цөмийн энергийн хууль 2009 онд бол анх батлагдан гарсан. 2009 оноос хойш энэ урантай холбоотой төслүүд бодитоор хэрэгжээгүй учраас бид энэ Цөмийн энергийн хуулиараа эрх зүйн орчныг бол боловсронгуй болгож чадаагүй.

Тийм ч учраас энэ гуравдагч хөрштэй хөрөнгө оруулалтын гэрээ яригдаж байгаа энэ цаг үед бол бид нар хууль эрх зүйн орчноо илүү тодорхой болгож цаашидын хэлэлцээр дээрээ энэ хууль эрх зүйнхээ орчинд тухайн хөрөнгө оруулагч талдаа ярих зайлиггүй шаардлага байна гэж ингэж үзэж байгаа. Тэгээд мэдээж төслүүдийн талаар би жишээ аваад яривал энэ төслийн ерөнхий мэдээлэл бол энэ Дорноговь аймгийн Улаанбадрах суманд хэрэгжих бол төсөл. Тэгээд дэлхий дахинд бол ер нь энэ дэлхий дээр уран олборлох 3 технологи л байгаа. Энэ 3 технологид бол ил далд уурхай, дагалдах бүтээгдэхүүн, тэгээд газрын доор уусган олборлох гэсэн технологиуд байдаг.

Тэгэхээр манай одоо энэ төсөл дээр бол бид газрын доор уусган олборлох технологиор энэ удаа ураныг олборлоно гэдэг 2023 оны урьдчилсан ТЭЗҮ боловсруулагдсан. Үүний давуу тал бол мэдээж зардал багатай байдаг. Байгаль орчинд үүсэх бохирдол нөгөө 2 технологио бодвол бага байдаг. Хатуу хог хаягдал бол бага байгаа. Нөгөө 2 технологиосоо бага байдаг.

Дээрээс нь усны хэрэглээ бол бага байдаг. Дээрээс нь хог хаягдал үүсэхээсээ илүүтэйгээр ураны 70-аас 90 хувийг нь ялгаж авах боломжтойгоороо бол илүү онцлогтой. Тэгэхээр энэ төслийг мэдээж урагшлуулахын тулд бол эхлээд бид нар дүрмээ тодорхой болгож хууль эрх зүйн орчноо бол зайлиггүй шаардлагуулах хэрэгтэй. Мэдээж энэ төсөл бол 1997 онд анх Рона групп төлөөлөгчийн газраа

нээсэн үеэс хойш л энэ төсөл яригдсан. Өнөөдөр 27 жилийн хугацааг үүдэж байгаа ийм төсөл. Гэтэл энэ 27 жилийн хугацаанд бол Казахстан улс энэ уран олборлолтоороо дэлхийд тэргүүлж эхэлсэн байна. Гэтэл бид 27 жилийн хугацаанд хэлэлцсэн ярилцсан тодорхой үр дүнд бол хүрээгүй.

Тийм учраас энэ стратегийнхаа хувьд гуравдагч хөршийн 2 дахь том хөрөнгө оруулалт, мэдээж эрэлттэй, эрэлт өндөртэй стратегийн бүтээгдэхүүнийг ашиглах цаашилаад бол Монгол Улс мэдээж зөвхөн энэ гуравдагч хөрштэй гэхээсээ илүүтэйгээр энэ бол АЦС-тай болоход нэг алхам урагшлахад ийм том ач холбогдолтой ийм төсөл. Тэгээд нийтдээ бол 1600 шинэ ажлын байрыг бий болгох, жилдээ бол 135 сая долларын ашиг олох, дээрээс нь орон нутгийн хөгжилд бодитой дэмжлэг үзүүлэх. Мөн энэ Эрдэнэт үйлдвэрийн элементийн хүхэрт түшиглээд хүхрийн хүчлийн үйлдвэр байгуулах дээрээс нь хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулж улсын хэмжээний нийт хог хаягдлыг дахин боловсруулах валютын урсгалыг нэмэгдүүлэхэд ийм өндөр ач холбогдолтой төсөл учраас бид үүн дээр одоо яг ажиллаж байгаа энэ цаг үед бол Цөмийн энергийн хуулийг өргөн мэдүүлж байна аа. Мэдээж энэ төсөлтэй холбогдуулаад Цөмийн энергийн хуультай холбогдуулаад ч гэсэн байгаль орчны чиглэлээр хэрхэн ямар ажлууд өрнөсөн бэ гэдэг талаар иргэдийн зүгээс ч гэсэн, Их Хурлын гишүүдийн зүгээс ч гэсэн нэлээдгүй асуултыг асуудаг.

Тэгэхээр 2013 онд Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуяг 104 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулаад дараа нь 2019 онд Мал эмнэлгийн даргын тушаалаар Оюун-Эрдэнэ сайдын тушаалаар хөндлөнгийн танцын компани академийн ерөнхийлөгчийн 2 удаагийн тушаалаар олон улсын атомын энергийн агентлагийн шинжээчдийн баг Мал эмнэлгийн дундын хоршоо гээд судалгаануудыг хийхэд бол

байгаль орчны чиглэлээр хийсэн судалгаануудаар олборлолт явагдах давхаргын усны чанарт металлуудын хэмжээ нэмэгдэж радоны эзлэхүүнд идэвхийн хэмжээ буурснаас өөр өөрчлөлт ороогүй гэдгийг нийт 16 худгаас гаргасан шинжилгээгээр нотолсон байдаг. Малчдын унд ахуйн зориулалттай худгуудын ус олборлолт явуулах давхаргын дээр орших давхаргын усны шинж чанар элементийн агуулгад өөрчлөлт ороогүй гэдгийг нийт 15 цооногоос авсан шинжилгээгээр бол харуулсан. Мөн хөрсний шинж чанар, бүрэлдэхүүн, хүнд хорттой элементийн агуулгад өөрчлөлт ороогүй гэдгийг харуулсан байдаг.

Тэгэхээр төслийн байгаль орчны талаас нь аваад үзэхэд бол Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны энэ үнэлгээгээр бол агаарын чанарт үзүүлэх нөлөө, ургамалд үзүүлэх нөлөө, амьтанд үзүүлэх нөлөө маш бага. Хөрсөнд үзүүлэх нөлөө газрын доорх усанд үзүүлэх нөлөө дунд гэсэн ийм үзүүлэлттэй бол гарсан.

Тэгэхээр цаашидаа бол төслийн үеийн хог хаягдлын менежментүүдийг хэрхэн боловсруулах вэ? Жилд жишээ нь 1600 тонн хаг хаягдал гаргаж байгаа бол үүнийг хэрхэн дахин боловсруулах вэ?

Дээрээс нь нөхөн сэргээх уурхайн хаалтын төлөвлөгөөнүүдийг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг чиглэлээр Цөмийн энергийн хууль дээр бол өөрчлөлт оруулахаар бид та бүхэнд өргөн мэдүүлж байгаа. Тэгэхээр энэ хуулиа гаргаж байж хөрөнгө оруулалтын гэрээг барихгүй бол хөрөнгө оруулалтын гэрээтэй хамтатгаж хууль өөрчилдөг бол өөрөө зохимжгүй ээ.

Тийм учраас бид бол өөрөө дүрмээ тодорхой болгохгүй бол 2009 онд баталсан энэ хууль бол өнөөдрийн шинэ хөрөнгө оруулалтын орчинд бол манай талд ашигтай байх эрх зүйн орчин биш байна гэж ингэж үзэж байгаа. Тийм ч учраас энэ хууль дээр дагалдан гарч

байгаа. Түрүүн та бүхэнд тайлбарласан төрийн эзэмшлийн хувийг АМНАТ -аар оруулах эрх зүйн орчныг яг Ашигт малтмалын хуульд заасны дагуу Цөмийн энергийн хуулиар зохицуулах шаардлага үүсэж байгаа. Ер нь бол төр өөрөө тухайн төслийн 34 хувийг эзэмшсэнээрээ менежментэд нь оролцоноороо төрд өр үүсдэг. Дээрээс нь санхүүгийн чадамжгүй байдалд хүрдэг. Тэгээд өмнөх хийсэн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу бол ингээд өнөөдөр шүүх дээр очдог ийм асуудал үргэлжилсээр байгаа юм.

Тийм учраас төр бол хувийн хэвшлийн ч бай, энэ хөрөнгө оруулагч нарын ч бай энэ бизнес сийн үйл ажиллагаанд оролцдог биш менежментэд нь оролцдог биш ер нь АМНАТ -аараа орлуулдаг бүтээгдэхүүн угаахаараа орлуулдаг энэ эрх зүйн орчныг нээе гэдэг зорилгоор бол энэ санхүүгийн үр өгөөжийг бид нар тооцсон. Энэ хүрээндээ бол та бүхэнд харж байгаагаар энэ санхүүжилтийн үр өгөөжийн харьцуулалтыг одоо манай ажлын хэсэг бол ажилласны үр дүнд 34 хувийг төр эзэмшсэн тохиолдолд суурь АМНАТ бол нэг 5 хувьтай тусгай өсөн нэмэгдэх АМНАТ гэж ойлголт байхгүй. Хэрвээ хуримтлалын санд нь тодорхой 10 хувийг нь ноогдол ашиг хэлбэрээр аваад дээрээс нь тусгай АМНАТ дээр бол 5 суурь АМНАТ дээрээ 5 гээд аваад үзвэл өсөн нэмэгдэх АМНАТ-ыг тооцох юм бол багадаа өнөөдрийн байдлаар 14 хувийн АМНАТ-ыг авч болох бололцоо бол байна. Яагаад гэвэл нэг фунт уран бол өнөөдөр 83 ам.доллартой тэнцэж байгаа учраас энэ бол тасралтгүй өснө. Тэр ч утгаараа хуулиа нээгээд хэлэлцээрийн үед шийдээд явъя гэдэг зорилгоор бол энэ хуримтлалын сан тодорхой хувийг нь аваад тусгай суурь өсөн нэмэгдэх АМНАТ-ыг бол хуульчилж өгөх нь хамгийн зөв хэлэлцээр үргэлжлэхэд дөхөм болно гэж зорьж байгаа.

Өнөөдрийн цөмийн энергийн хуулиар бол энэ АМНАТ-ын дээд таазыг бол 5 хувь гэж заасан. Тэрийг

хэлэлцээрийн үед зөрчих бололцоо байдаггүй. Гэтэл Монгол Улсын Ерөнхийлөгч Франц улсад хийсэн төрийн айлчлалын үеэр энэ протоколд гарын үсэг зурахад протокол дээр 10 хувийн ноогдол ашиг өсөн нэмэгдэх АМНАТ-ыг тооцож болно гэдгийг АМНАТ-ын үеэр тохиролцсон. Гэтэл манай Цөмийн энергийн хуулийг харахаар дээд тааз нь 5 хувь гэхээр бид нар хөрөнгө оруулалтын гэрээ хийх ийм эрх зүйн орчин бол байхгүй байгаа. Нэг ёсондоо бол Ашигт малтмалын хуулиар хэдийгээр зохицуулагдчихсан харилцаанууд байгаа ч АМНАТ-аар орлуулах нь Цөмийн энергийн хуульд алга.

Дээрээс нь өсөн нэмэгдэх АМНАТ гэдэг бол манай хуулийн эрх зүйн орчинд бол алга аа. Тийм учраас хуулиа нээгээд хэлэлцээрээ хууль эрх зүйн орчиндоо явуулах юм бол төслийн хугацаанд бид эхний хөрөнгө оруулалт дээр бол хэрвээ 10 хувийн ноогдол ашиг тусгай өсөн нэмэгдэх АМНАТ гээд тооцох юм бол манайд улсаас Засгийн газраас ямар нэгэн санхүүжилт шаардлагатай огт биш. Хэрвээ төр эзэмшлийн 34-ийг авах юм бол анхны хөрөнгө оруулалт дээр төр 125 сая ам.долларыг төлөх үүрэг хүлээж байгаа. Цаашидаа энэ ноогдол ашиг бол авах хугацаа нөгөө зардлаа өсгөөд байдаг менежментийн зардлаа өсгөөд байдаг. Тэгээд ноогдол ашиг авах хугацаа бол хэдий хугацаанд хойшлохыг бол бид мэдэхгүй.

Тийм учраас өмнөх одоо хөрөнгө оруулалтын гэрээний алдааг дахин давтахгүйн тулд төрөөс ямар нэгэн санхүүжилт шаардахгүйгээр ирээдүйд үүсэх өр үүсэхээс урьдчилан сэргийлж ер нь баялгийн сангийн хуулийн 34, 50 хүртэлх хувийг төр эзэмшинэ гэдэг болиргэд ноогдол ашигаа л хүртэхийг хэлж байгаа болохоос ямар хэлбэрээр хүртэх нь бол зөвхөн 34 гэдэг сонголтгүй байж бол болохгүй ээ.

Тийм учраас энэ АМНАТ-аар орлуулах зохицуулалтыг хийж өгсөн. Энэ

бол протоколд туссан хэмжээ. Өнөөдөр цөмийн энергийн хууль дээр яг энэ протоколд туссаных нь дагуу бид нар ингэж оруулж өгч байгаа. Жишээ нь 80-90 хүртэлх үнэ байх юм бол өсөн нэмэгдэх АМНАТ дээр 4 гэж тооцогдох юм байна. Ирэх жилүүдээс хэрвээ 90-ээс дээш доллароор гараад явах юм бол 5, 6, 7, 8, 9 гээд дээд талдаа 19 хувь одоо хамгийн багадаа 14 хувийн АМНАТ тооцно гэж ийм зохицуулалтыг хийхийн тулд дараах бид нар өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгасан. Энэ бол хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр энэ эзэмшлийн 34 хувийг орлуулж болох эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Хуульдаа нэмэгдүүлэн тооцох АМНАТ-ыг яг одоо ингээд үнийн түвшинтэй нь үнэ тооцоод хэрхэн ноогдох хувийг ноогдуулах вэ гэдгийг тусгасан. Дээрээс нь тусгай АМНАТ дээр орлуулах асуудлыг бол Засгийн газар шийдэхгүй мэдээж энэ Их Хурлын бүрэн эрх учраас дараагийн Хөрөнгө оруулалтын гэрээ бол Их Хурлын тогтоолтойгоо хамт орж ирээд тогтоолыг дагуулаад хэдэн хувь нь АМНАТ-аар орлуулах юм бэ? Яаж шилжүүлэх юм бэ гэдгийг Их Хурал бол шийднэ. Мөн сая дурдсан байгаль орчинтой холбоотой энэ аюулгүй ажиллагаа, уурхайн хаалт, нөхөн сэргээлт хог хаягдлын менежмент дээр бол бид нар гадаад улсын цацраг идэвхт хаягдал ашигласан цөмийн түлшийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглох гэдэг энэ заалтыг бол хуульд хийж өгч байгаа.

Энэ хуульд тусгагдаагүй байсан заалт. Дээрээс нь удахгүй бол манайх яг энэ чиглэлээр бол 3 конвенцод бол нэгдэнэ. Тэр утгаараа бол хуулиар хориглож байгаа. Дээрээс нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нар дээр тавигдах шаардлагуудыг нэмж өгч байгаа. Өмнө нь бол 3 шаардлага л байсан. Тэгэхээр одоо 2009 оноос хойш өөрчлөгдөөгүй хууль учраас тусгай зөвшөөрөл эзэмшиж

байгаа эзэмшигч нарт ямар шаардлага тавих вэ гэдгийг тусгаж өгч байгаа. Өмнө нь цацрагийн хамгаалалтын хөтөлбөр төлөвлөгөөг бол компани өөрөө батлаад явдаг байсан бол одоо Цөмийн энергийн комиссын улсын байцаагчаар хянаж баталж мөрдүүлэх ийм хариуцлагыг тодорхой болгож өгч байгаа. Мөн уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулж 5 жил тутам шинэчлэн батлуулахыг үүрэг болгож байгаа. Ингээд уурхайн хаалтын төлөвлөгөөг бол 5 жил тутам шинэчилж баталж явж байгаад нөхөн сэргээх ажил эхлэхэд бол яг тэр төлөвлөгөөнийхөө дагуу үйл ажиллагаагаа явуулах, дээрээс нь уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд заруулж зарцуулах мөн мөнгөн хөрөнгийг тооцож төрийн дансанд байршуулъя гэж байгаа юм. Энэ бол өнөөдөр Байгаль орчны хуулиараа уурхайн салбар бол угаасаа энэ мөнгөн хөрөнгө байршуулдаг юм байна одоогийн хуулиараа. Гэтэл Цөмийн энергийн хуулиар энэ зохицуулалт хийгдэж байгаагүй юм байна.

Тийм учраас энэ мөнгөн хөрөнгийг байршуулаад тэр мөнгөн хөрөнгө нь юунд зориулагддаг вэ гэхээр хэрвээ нөхөн сэргээхгүйгээр ч юм уу тэр нөгөө хөрөнгө оруулагч тал гараад явах юм бол түүнийг нь менежментийн компаниар нөхөн сэргээх ажлыг нь хийлгэдэг бол уул уурхайн салбарт угаасаа хэрэгждэг ажил юм байна. Үүнийг нь Цөмийн энергийн хуулиар бол бид нар шийдэж өгөөгүй байсан байна. Үүнийг шийдэж өгье гэж байгаа. Хуулийн давхардал хийдлийг арилгая гэж байгаа. Энэ бол мэдээж олон улсын атомын энергийн агентлагаас гаргасан стандарт зөвлөмжид нийцүүлж энэ заалтуудыг оруулж өгч байгаа. Мөн хөрөнгө оруулалтын гэрээний хугацааг сунгая гэсэн ийм зорилготой байгаа. Хөрөнгө оруулалтын гэрээний хугацааг тусгай зөвшөөрлийн хугацаатай нь уялдуулах зорилгоор 20 хүртэлх жилээр байгуулж болохоор тусгасан. Энийг Их Хурал шийднэ.

Тэгэхдээ мэдээж энэ чинь тусгай зөвшөөрөл явах нь хугацаа заачихсан байхад үнэ хөрөнгө оруулалтынх нь гэрээ нь наана нь дуусна гэдэг бол өөрөө тийм хөрөнгө оруулагч талдаа тийм таатай зүйл бол биш. Тийм учраас бол хөрөнгө оруулагч талын эрх ашгийг ч гэсэн хангуулах үүднээсээ илүү тогтвортой байлгая энэ гэрээгээ гэдэг зорилготой байгаа. Ингээд энэ хуулийг дагалдуулаад Татварын ерөнхий хууль, Хөрөнгө оруулалтын хууль, Компанийн хуульд өөрчлөлт оруулж байгаа юм.

Хэрвээ бид төрийн эзэмшлийн 10 хувийн хувьцааг энгийн хувьцаагаар авах юм бол санхүүжүүлэх үүрэг хүлээх эрсдэлтэй учраас хэлэлцээрийн протокол дээр тусгачихсан манай талын байр суурийн дагуу энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаа болгож шилжүүлэх асуудлыг Компанийн хуулиар зохицуулж өгөөд хөрөнгө оруулагч нартай гэрээний үед энгийн хувьцаагаа давуу эрхийн хувьцаа болгоод гэрээндээ тусгачихвал санхүүжүүлэх үүрэг бол огт хүлээхгүй гэж байгаа. Бид бол эхлээд тавьсан санал бол одоо хэд хэдэн хувилбар байна гэсэн. Хөрөнгө оруулагч тал бол төр тодорхой хувийг эзэмшээд хуримтлалын сан руугаа ав. Энд оролцох ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа. Тийм бол бид нар энийг давуу эрхийн хувьцаанд шилжүүлэхийг хуулиар нь нээе гэж зорьсон. Татварын ерөнхий хууль дээр бол нөгөө Тогтворжуулах татварын орчин гэдэг энэ зохицуулалтыг эшлээд 4.1.11-д татварын хувь хэмжээг Хөрөнгө оруулалтын хуульд заасны дагуу тогтворжуулах гэснийг нөгөө Цөмийн энергийн хуулиар зохицуулагдаж эхэлж байгаа учраас Хөрөнгө оруулалтын хууль Цөмийн энергийн хуульд заасны дагуу гэж давхар хуулийн давхардлыг арилгаж хуулиудыг хооронд нь нийцүүлж ингэж өгсөн ийм дагалдсан 3 хуулийг энэ Цөмийн энергийн хуулийг дагалдуулаад өргөн мэдүүлж байгаа. Тэгээд мэдээж цаашаа бол урантай холбоотой асуудал буюу энэ цацраг идэвхт ашигт малтмал гэдэг бол

өөрөө стратегийн бүтээгдэхүүнд тооцогддог.

Тийм ч учраас бол бид энэ Цөмийн энергийн хуулиараа энэ гэрээгээ цаашидаа хийгээд явах ёстой. Тэгээд энэ бол зөвхөн нэг төсөлтэй холбоотой биш. Цаашидаа энэ ураны олборлолт хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулах хувийн хэвшил аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулагч нар бол энэ хуулийн дагуу Засгийн газртай хэлэлцээр хийгээд ингээд Их Хурлаар асуудлуудаа яриад шийдээд явах ийм аль аль талдаа үр өгөөжтэй байх энэ үндсэн зарчмыг хангуулж байгаа.

Хэрвээ одоогийнхоо хуулиар явах юм бол бид нар хатуу төрийн эзэмшлийн 34 дээрээ байх болно. Тэгээд менежментэд оролцсоноороо ямар үр дүнд хүргэж байгаа вэ гэдгийг өнгөрсөн хугацааны бид нарын олон алдаанууд бол илтгэж харуулж байгаа.

Тийм ч учраас ер нь цаашидаа бид нар Баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэхдээ ч гэсэн хувийн хэвшил хөрөнгө оруулагч нарын менежмент нь оролцдог биш АМНАТ-аар орлуулдаг бүтээгдэхүүн угаахаар орлуулдаг. Эргээд Үндсэн хуулийн 6.2 хангагдаж байх энэ суурь зарчмаа л бол барьж явах нь улсдаа эргээд ашигтай байна гэдэг ийм зорилгоор Цөмийн энергийн хуулийг та бүхэнд танилцуулж байна. Тэгээд хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье ээ.

Г.Тэмүүлэн: Учрал сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хууль санаачлагчаас асуулттай гишүүд байна уу? Кнопоо дараарай Батсүмбэрэл гишүүн байна уу? Хамгийн сүүлийнх нь Номтойбаяр гишүүн. Номтойбаяр гишүүнээр тасаллаа.

Эхнийх нь Сайнзориг гишүүн байна. Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Ерөнхийдөө Монгол Улсад хөрөнгө оруулалт татъя гэвэл Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулгыг яаралтай оруулж ирэх, дээрээс нь энэ стратегийн салбар болох энэ Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт хөрс болон газрын хорыг хэрхэн яаж ашиглах бодлогоо илүү тодорхой болгоод ашиглаж байж цаашидаа бид нар гуравдагч хөршдөө ялангуяа технологи эзэмшиж байгаа эдгээр хөрөнгө оруулагчтай ярилцаж байж энэ улсын эдийн засаг аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажиллах юм байгаа юм.

Ингэхгүйгээр бид нар зүгээр наана нь авах юм бол цаг хугацаа алдана. Энэ асуудлуудаас болж цаашидаа олон шийдэж болох асуудлууд боломжуудаа бид нар өнгөрсөн цаг хугацаандаа алдсан байж байгаа. Тэгэхээр энэ дээр бол бас зарчмын хувьд оруулж ирж байгаад дэмжиж байгаа юм.

Хоёрдугаарт яах вэ зүгээр энэ хуулийн төслийн хувьд бол нэг зүйл байгаа. Яг одоо хуулийн төсөл гэхээсээ илүүтэйгээр яг энэ төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээг хийхтэй холбоотойгоор бас олон нийтэд мэдээллийг зөв өгч явахгүй бол энэ дээр юу гэдэг юм гадна дотнын гар хөл болсон хүмүүс энэ хөрөнгө оруулалтын гэрээг зогсоох оролдлогуудыг хийдэг. Иргэдийг буруу мэдээллээр хангадаг, турхирдаг эргээд ийм нөхцөл байдлууд байгаа. Тэгэхээр энэ дээрээ анхаарна биз.

Хоёрдугаарт яах вэ зүгээр би энэ төслийг бас Ерөнхийлөгчийн айлчлалаар гарын үсэг зурах энэ хэлэлцээрийг ахалж хийсэн хүн байгаа. Ерөнхийдөө энд сууж байгаагаас Тэлмүүн харагдаж байна. Тэгэхээр энэ концептууд ерөнхийдөө баригдаж байгаа байх гэж би найдаж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол стратегийн ач холбогдолгүй ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр орлуулах бүтээгдэхүүн хуваах

төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэргээр бас энэ Цөмийн энергийн тухай хуулийн 5.4-ийг өөрчилж байна л даа.

Тэгэхээр энэ дээр зүгээр бето эрхүүд авах асуудлыг хууль дээр тусгайлан оруулж ирсэнгүй юу? Эсвэл зүгээр хөрөнгө оруулалтын гэрээгээрээ шийдээд тохиролцоод явна гэж үзэж орж ирэв үү? Энийг нэг хэлээч.

Хоёрдугаарт яах вэ энэ АМНАТ, АМНАТ-ыг авах, өсөн нэмэгдэх болон тусгай АМНАТ-ыг авах асуудал ингээд хөндөгдөөд ороод ирж байгаа нь зөв. Бид одоо ингэж хөрөнгө оруулалт хийж, менежмент нь оролцож, өмнөх гаргасан энэ алдаанууддаа давтах ерөөсөө хэрэг байхгүй. Энэ чиглэлийн зүгээр сонирхлууд бол байдаг. Зарим хүмүүс ажилтай төрөлтэй байхыг эрхэмлэдэг. Менежментийн нэг 34 хувьд нь оруулчихвал Монгол талаас нэг захирал томилогдоно ч гэдэг юм уу? Нэг ийм өчүүхэн жижигхэн юмнаас болж энэ төслийг бас нэг саатуулдаг буруу мэдээллээр шийдвэр гаргаж байгаа хүмүүсийг хангадаг ийм хэсэг бүлэг хүмүүс манайд бий шүү. Энийг анхаарах ёстой.

Тэгэхээр энэ АМНАТ дээр тэр 5.4-ийг өөрчилж байгаа тэр бета эрхүүд авах уу? Энэ хувьцааны төрлүүд гэдэг дээр нь 10 хүртэл хувийн хувьцааг үнэгүй өгье гэж байгаа санал байгаа. Давуу эрхийн хувьцаа. Дээрээс нь алтан хувьцаа ч гэдэг юм уу ийм төрлүүд байгаа. Аль болох энэ бүх төрлүүд орж байгаа биз дээ гэдэг зүйлийг нэг тодруулаад асуучихъя гэж бодож байгаа юм.

Тэгээд ер нь зүгээр НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн 5 орны 1-тэй бас хөрөнгө оруулалтын гэрээ хийнэ гэдэг бол маш том стратегийн ач холбогдолтой байна. Хүлэмжийн хийг бууруулах, ногоон эдийн засаг ярьж байгаа. Цаашидаа цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг ярьж байгаа энэ үе дээр энэ зайлшгүй явах төсөл байж

байгаа юм аа. Өнөөдөр одоо цэвэр эрчим хүчний чиглэл дээр технологиуд бол нэлээн сайн хөгжссөн байна. Зөвхөн усан хөргүүртэй биш, газар хөргүүртэй, молтан суулт буюу энэ давсан хөргүүртэй ч байж энэ цөмийн энергийг одоо цөмийн эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашигладаг орны технологиуд бол үндсэндээ хэлэхэд маш өндөр хэмжээнд оччихсон байна. Тэгэхээр бид хэд зүгээр энэ чиглэлийн суурийг эртнээс бодож зайлшгүй анхаарах ёстой юм аа.

Тийм учраас энэ төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа. Зүгээр хэлэлцээрийн хувьд нэг хөндөгдөж ярьж чадаагүй нэг асуудал энэ усны асуудал байдаг юм. Энэ усны төлбөрийг зүгээр арай энэ ураны төсөл дээр өөрөөр тогтоох бодлого байгаагүй юу?

Г.Тэмүүлэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя, Учрал сайд.

Н.Учрал: Сайнзориг гишүүн их чухал асуудлыг хөндөж байна аа. Тэгээд үнэхээр энэ Цөмийн энергийн хууль бол 2009 оноос хойш өөрчлөгдөөгүй нэмэлт, өөрчлөлт ороогүй. Тэгээд ингээд яваад ирчихсэн. Тэгээд сая одоо тэр Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр протокол зурахад бол эрх зүйн орчин байхгүй учраас бид ямар дүрэм дээр гэрээ хийх вэ гэдэг нь ойлгомжгүй. Тэгээд нөгөө тал нь өсөн нэмэгдэх АМНАТ-даа тооцвол тооцъё гээд хэлэлцээд байдаг. Гэтэл манай хуулиа харахаар хэнд зориулаад тэгээд дээд талын тааз нь 5 байна гээд нэмж болдоггүй хууль хийгээд хаячихсан нь ойлгомжгүй.

Тэгэхээр үүнийг бид зүгээр хууль энэ чинь хууль болохоос биш нэг төслийг хэрэгжүүлэхэд зориулж бид хууль гаргаж болохгүй. Тийм учраас энэ хууль бол Монгол Улсын Их Хурлаас батлагдах хууль учраас цаашидаа энэ ураны олборлолттой холбоотой олон л төсөв л орж ирэх байх. Тэгэхээр ер нь үүнийг чөлөөтэй энэ таазыг нь чөлөөлье тэгээд

АМНАТ-аар оруулахыг нь нээе ээ. Шаардлагатай бол бүтээгдэхүүн хуваахаар орлуулж болдог байг ээ. Тэр компанийн хуулиар ч гэсэн энгийн хувьцааг давуу ерөнхий хувьцаа болгох боломжийг нь нээе ээ. Ингээд энэ хууль дээр заасан болгон өөрөө гэрээнд тусгагдана гэдэг үг бол мэдээж огт биш. Эрх зүйн орчин нээгдчихвэл бид нар нөгөө хэлэлцээнийхээ явцад энэ эрх зүйн орчиндоо яриад одоо тэгвэл 10 хувийн ноогдол ашиг гэвэл энгийнийг давуу орчин болгож болох эрх зүйн орчин байна аа.

Дээрээс нь Цөмийн энергийн хууль дээр энэ төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг Монгол Улсын эдийн засагт үр ашигтай байхыг хувь хэмжээг Засгийн газар мэдүүлээд Их Хурал тогтооно гэхээр гэрээ болгоны кэйс дээр нь үндэслээд Их Хурлын тогтоолыг нь хамтатгаж бариад тэгвэл үүн дээрээс АМНАТ-аар тэдийг нь орлуулъя бүтээгдэхүүн хуваахаар тэдийг нь орлуулъя, тэд нь ноогдол ашиг байя. Ноогдол ашиг нь хуримтлалын санд оръё. Ер нь тал бүр өөрөө ашигтай байх ёстой.

Тийм учраас баялгийн сангийн хуулийг гаргахдаа бид нар нөгөө 34 бол өөрөө хуримтлалын санд очно оо. Хуримтлалын сан гэр бүл, эрүүл мэнд боловсролд зарцуулагдана. Ирээдүйн өв санд АМНАТ-ын 65 хувь очно. Үлдсэн нь Орон нутгийн сан, Тогтворжуулалтын санд орно гэдгийг маш ойлгомжтой болгочихсон.

Тэгэхээр энэ төсөл хэрэгжиж эхэлснээрээ яг сая Сайнзориг даргын хэлдгээр 5.4 дээр энэ бид нар үүнийг чөлөөтэй орхиж байгаа учраас хөрөнгө оруулалтын гэрээний явцад шийдлээ боловсруулаад Их Хуралд өргөн мэдүүлээд явна. Тэгээд энэ бол цаашидаа мэдээж уран олборлолттой холбоотой ямар ч төсөл энэ эрх зүйн хүрээнд бол урагшилна гэдэг ийм хүлээлттэй бол байгаа.

Г.Тэмүүлэн: Сайнзориг гишүүн нэмж тодруулъя.

П.Сайнзориг: Ямар ч байсан Учрал сайдад баярлалаа. Энэ төсөл яах вэ хэлэлцээрийнхээ явцад бид нар ямархуу хувилбараар АМНАТ-ыг авч болох буюу эрсдэлгүйгээр Монгол Улс үр өгөөж хүртэж болох вэ гэдэг дээр тохирч байж холбогдох хуулийн өөрчлөлтийг хийнэ гэдгийг Францын хөрөнгө оруулагчдаа түрүүн жил би яг наадмын дараа нь тасралтгүй Ерөнхийлөгчийн айлчлал хүртэл хийж байсны хувьд мэдэж байгаа. Тэгэхээр эд нар бол нөгөө талдаа энийг хүлээн зөвшөөрч байгаа. Яах вэ зүгээр айлын талаас бол 2015 онд манайхыг лоббидож байгаад өөрчлөлт оруулсан 5 хүртэлх гэдгээрээ бүх зүйлээ тооцчихоод байсан. Бид нар энийг бол хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй гэдэг зүйлийг хэлэлцээрийн хувьд хэлж байсан байгаа.

Тэгэхээр энэ дээр бол ямар ч байсан тууштай цаашидаа явах ёстой. Хөрөнгө оруулалт хийхгүйгээр эрсдэлгүйгээр үр өгөөж хүртэх чиглэлээрээ хэлэлцээрийг баримтлаарай гэдэг зүйлийг хүсмээр байна. Зүгээр яах вэ энэ дээр усны төлбөрийг юм уу ус бохирдуулсны төлбөрийг чухам бас нэг ураны орд дээр ашиглаж байх дээр арай үнэ өөрөөр тогтоох асуудлыг уг нь нэгмөсөн хөндөн ороод ирсэн бол бас хэлэлцээрийн.

Г.Тэмүүлэн: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ Татварын ерөнхий хуулиар тэгээд Татварын ерөнхий хуулиар бол нөгөө татварыг тогтворжуулах, бүхэлд нь тогтворжуулах гэдэг агуулга ингээд орж ирж байгаа. Мэдээж хөрөнгө оруулагч нартай гэрээ хийхэд тогтворжуулах асуудал яригддаг. Гэхдээ Сайнзориг гишүүн жишээ нь нөгөө ажлын хэсэгт ажиллаж байхдаа бол мэдээж байр суурь барьж байсан. Байгаль орчинтой холбоотой орчныг тогтворжуулахгүй л гэж байна, тогтворжуулахгүй гэж. Тэгээд бид нар

ийм байр суурьтай л байгаа. Ус бохирдуулсаны байна уу, ус ашигласны байна уу, энэ татварыг бол тогтворжуулаагүй байгууллага бол байхгүй ээ. Гэхдээ үүн дээрээ бол хэлэлцээрийн явцад эрх зүйн орчиндоо баригдаад байх зүй байхгүй учраас хэлэлцээрийн явцад бол үргэлжлүүлээд энэ асуудлаа яриад явж бол болно гэж үзэж байгаа. Тэгээд ажлын хэсгээс бас нэмээд хариулчихъя.

Хэн Жаргалсайхан доктор хэлэх үү?

Г.Тэмүүлэн: Хэн хариулах вэ? 9 номер.

З.Батбаяр: Усны газрын дарга Батбаяр. Сая Учрал сайдын хэлсний дагуу усны төлбөрийн асуудал буюу усны асуудлыг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу шийдвэрлэнэ гэдэг байдлаар гэрээнд тусгах учраас Улсын Их Хурлаас усны төлбөрийг ямар хэлбэрээр нэмж болно, ямар хэлбэрээр өөрчилж болно тэр нь тухайн үедээ хүчин төгөлдөр мөрдөгдөөд явчихна л гэсэн ийм байр суурьтай байгаа учраас гишүүний асуусан асуултад уранд зориулсан тусгайлсан төлбөрийг нэмэх юм уу, шинэ төлбөр бий болгох боломж нь хадгалагдаж үлдэнэ гэж хариулмаар байна.

Г.Тэмүүлэн: Батбаатар гишүүн асуулт асууж.

Б.Батбаатар: Цөмийн энергийн тухай мөрдөгдөж байгаа хүчин төгөлдөр байгаа хууль нь бол энэ чиглэлд хөрөнгө оруулалт хийгдэх, гэрээ хэлэлцээр хийгдэх, олборлох, ашиглах тэр боломж нь хаалттай боломжгүй юм байна гэдэг үүднээс Засгийн газар дээрээс нь Монгол Улсад ашиггүй юм байна ямар нэг байдлаар гэдэг үүднээс нэг 7 орчим хуульд өөрчлөлт оруулахаар төслийг оруулж ирж байгаа юм байна гэж ойлголоо танилцуулгаас. Энэ Цөмийн энергийн тухай хууль дагалдах хуульд өөрчлөлт

оруулах асуудлыг Засгийн газар бол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ яаралтай горимоор хэлэлцүүлье гэж Улсын Их Хурлын чуулган дээр санал хураалгаад ингээд яаралтай горим руу шилжчихсэн.

Тэгэхээр хэдийгээр яаралтай горимтой байгаа боловч бид нар зарим зүйлийг нь жосоохон анхаарах хэрэгтэй. Энэ 7 зүйл дээр нэг тодорхой зөвлөмж санал байна. Тэрийг асуултынхаа цаг дээр биш санал хэлэх үедээ хэлчихье. Ер нь энэний энэ 7-оос гадна өөр орхигдчихсон байгаа зүйл байна уу? Миний харж байгаагаар сая одоо устай холбоотой байгаль орчны үнэлгээ, шинжилгээтэй холбоотой, дээрээс нь тэр 10-аас 20 жил болгож байгаа асуудал чинь ерөнхийдөө хугацааг нь сунгаж өгч байна гэдэг чинь тэр нөгөө явцын хяналтыг сайжруулах тэр тухай асуудал нь бол энэ төсөл дээр харагдахгүй байгаад байгаа юм. Зүгээр хугацааг нь сунгаад тэр хугацаан дотор нөгөө богино хугацаа чинь бол зайлшгүй өндөр хариуцлагатай ажиллахыг шаарддаг байхад тэр явцын хяналтгүйгээр зүгээр хугацаа сунгачихсан юм уу гэж харагдаад байгаа. Дахиад нэг 2, 3 хууль дээр өөрчлөлт оруулах шаардлага байна гэж нутгийн удирдлага гэдэг юм уу, юу гэдэг юм, тэр юу эд нар дээр нэг оруулах шаардлагууд байна гэж надад харагдсан.

Тэгэхээр энэ хууль хэлэлцээд эхэлж байхад энийг батлах явцад хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараа Байнгын хороо шийдээд ингээд гаргасны дараа тэр саналуудыг аваад хуулийн төслийг ингээд нэмээд оруулчих боломж байгаа юу?

Хэрвээ тийм боломжгүй гэвэл одоогоос нь энийг нь ярьж эхлэхгүй бол болохгүй болоод эхлэх юм байна.

Г.Тэмүүлэн: Учрал сайд асуултад хариулъя.

Н.Учрал: Энэ 1997 онд анх төлөөлөгчийн газраа нээгээд л эхэлсэн юм байна лээ. Тэгээд яах вэ 2013 онд

Алтанхуяг сайдын үед нэлээн ахисан. Тэгээд 1 хэсэг намжсан. Тэгээд нөгөө 2 Ерөнхийлөгчийн айлчлал Монголд, Францад өрнөөд, тэгээд нэлээн удаан манлайлал бий болж гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтыг татах энэ ажил бол хурдассан. Тэгээд ер нь бараг би энэ ажлын хэсгийг ахалж байгаа бараг арван хэд дэх 15, 16 дахь сайд болж байгаа байх.

Тэгэхээр энэ хуулийг бол үеийн үед л тэр ажлын хэсгийн ахлагч нар нэг хэлэлцүүлээд л бариад л явдаг л байсан юм билээ. Тэгээд сая бол ажлын хэсэг дээр бол яг нөгөө энэ Цөмийн энергийн хуулийг дагалдуулаад Ашигт малтмалын хуулийг хөндье гэдэг саналыг зарим гишүүд гаргаж байсан. Би бол ямар байр суурьтай байсан бэ гэхээр ер нь гуя дагуулж хүзүү гэж юм байж болохгүй ээ. Энэ бол өөрөө Цөмийн энергийн хуулиараа л зохицуулах харилцаа. Тэрнээс биш тэр Ашигт малтмалын хуулийг хөндөгдөж байгаа бол тэр салбарын яам, Дахиад хэлэлцүүлэг хийж байж ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа тэр бүлгүүдийн сонирхлыг нь сонсож байж ингээд зөвшилцөж байж оруулж ирэх ёстой.

Тийм учраас энэ Цөмийн энергийн хууль харин дангаараа Татварын хууль, Компанийн хууль хэдэн хуультай орж ирээд батлагдвал нөгөө хэлэлцээрийн протоколд дурдагдсан асуудлуудыг амилуулахад хэрэг болох юм байна л гэж ойлгосон.

Тэгээд 2-т бол та Батбаатар гишүүн сая хэлж байна. Тэр 20 хүртэлх жил эсвэл нөгөө АМНАТ-аар орлуулах гээд энэ асуудлууд бол Их Хурал шийдэх учраас тэр хугацааг хэдээр тогтоохыг мэдээж Их Хурлын бүрэн эрх дээд тааз нь хэд байгаа вэ гэдгийг хуульд нь ерөнхийдөө ингээд нээгээд өгчихвөл хэлэлцээ яаж явахаас шалтгаална.

Дээрээс нь төсөл болгон кэйс болгон өөр. Тэгээд кэйс, кэйс дээр тус тусад нь ингэж асуудлаа ярьж байхгүй бол мэдээж энэ чинь кэйс нь өөр. Гэтэл

түрүүн Сайнаа гишүүний хэлж байгаагаар үнэхээр ингээд 5 хүртэлх гээд ингээд АМНАТ-ыг ингээд хатуу дарчихсан чинь хэний лобби байсан юм бэ гээд хүмүүс эргэлзэж байна шүү дээ. Яагаад? Тэгээд ингээд хийх гэхээр хуульдаа ингээд баригдчихаад байдаг. Нөгөө тал гэхэд хэлэлцээр дээрээ протокол дээрээ өсөн нэмэгдэх АМНАТ өгье өө. Суурь нь 5, тусгай нь 5 нэмэх нь өсөн нэмэгдэх гээд байхад хуулиа харсан чинь болдоггүй. Монгол талд ашигтай байх гэхээр хууль нь болохоор ашиггүй хуультай.

Тэгэхээр эхлээд хуулиа хийххээд нөгөө талтайгаа бид ийм хуультай үүний дагуу шийднэ гээд явбал энэ зохимжистой байх гэж бодоод байгаа юм. Тэгээд яаралтай горимоор гэдгийн шалтгаан цаг ер нь алдаж болохгүй юм байна лээ. 27 жил гэдэг дэндүү удаан хугацаа.

Хоёрт бол энэ ураны үнэ жил ирэх тусам өсөж байна. Ирэх жил бол дэлхийд 120 мянган тонн уран хэрэгтэй юм байна. Тэтэл 80 мянгыг л үйлдвэрлэж чадах юм байна. Тэгээд дахиад л эрэлт үнэ нь өсөөд ирнэ. Тийм учраас.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Сайн байцаана уу? Ажлын хэсгээс 2 санал, нэг асуулт байна. Саналаа эхлээд шууд хэлчихье.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуультайгаа уялдана гэдэг заалтыг заавал ч үгүй оруулж ирмээр байна. Ашигт малтмалын тухай хуулийн 2.1 дээр заасантайгаа адилхнаар энэ одоо бол явцын үеийн байгаль орчны нөхөн сэргээлт ослын үеийн нөхөн сэргээлтийн асуудал, хаалтын дараах гэсэн ийм олон 3 үндсэн хүчин зүйлээр заалтууд орж ирсэн байна. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.4, Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний байдлын тухай хуулийн 9.9 гэсэн заалтуудтай уялдуулах заалтыг заавал ч

үгүй оруулж ирэхгүй бол энэ явц дараа нь хуулийн цоорхой болох эрсдэл байх вий. Ийм санал байна.

Хоёрдугаар санал. Энэ яаралтай горимоор орж ирсэн Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, гадаад бодлогын хувьд чухал ач холбогдолтой процессын ийм шаардлага хангуулж оруулж ирмээр байна. Энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн 19.1 дээр яаралтайгаар өргөн мэдүүлж байгаа тохиолдолд Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 33-д заасны дагуу Хууль зүйн сайд хууль зүйн дүгнэлт гаргаж ирүүлэх ёстой. Гэтэл энэ Хууль зүйн сайдын 2024 оны 10 сарын 24-ний 1/1445 тоот дүгнэлт дээр шаардлага хангасан байна гэсэн болохоос ямар эдийн засгийн аюулгүй байдлаас хууль зүйн дүгнэлт байхгүй байна.

Тэгэхээр энэ хууль зүйн дүгнэлтээ энэ хууль хэлэлцүүлэх үеэр хангаж оруулж ирэхийг хүсье. Алтангэрэл сайд аа.

Асуулт энэ цөмийн энергийн комиссоос оруулж ирсэн заалт энэ 34.5 буюу энэ уурхай ашиглаж дууссаны дараагаар орж ирж байгаа мөнгөн хөрөнгийг 34.6-д заасан журмын дагуу тооцож төрийн дансанд байршуулна гэж байгаа юм. Энэ төрийн дансанд байршуулдаг жишгийг аваад үзэхээр энэ Цөмийн энергийн тухай хууль дээр 28.9-өөр одоо яг энэ Бадрах энерги дээр ер нь 900 мянган долларыг УУЯ-ны төрийн дансанд байршуулсан юм байна. Энэ нь ерөөсөө эдийн засгийн эргэлтэд ордоггүй, ханиш нь унаад байдаг.

Тэгэхээр энэ яагаад заавал төрийн данс юм бэ? Энийг эдийн засгийн нэлээн томоохон үнийн дүн орж ирэх гэж байгаа бол олон улсын санхүүгийн баталгааны механизмуудаар эдийн засгийн эргэлтэд оруулдаг төрийн тусгай данс юм уу өөр байдлаар байршуулж болоогүй юм уу?

Хоёрдугаарт энэ журам гээд байх юм. Журмаа цөөлнө гээд парламент нь яриад байдаг. Гэтэл энэ журмаа цөөлөх

хүрээнд нь энэчээ ажиллаад байхаар энэ дахиад нэг журам. Энэ журам нь аягүй эргэлзээтэй. Өөрөөр хэлбэл энэ гэрээг үндсэнд нь байхгүй болгох боломжтой журам байгаа байхгүй юу. Засгийн газар нь солигдох юм уу, Засгийн газар нь энэ журмыг Их Хурлаараа хамаарахгүйгээр 33 жилийнхээ хаалтын дараах төлбөрөө урьдчилж авах юм уу. Дараа нь авах юм уу хэсэгчилж авах юм уу? Энэ тодорхойгүй.

Энэ нь өөрөө цаашилаад яг энэ цөмийн энергийн тухай, гаднын хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн салбарын хөрөнгө оруулалт дээр асар том гай болохоор ийм заалтууд байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ 34.5, 34.6-г яагаад ингэж журам гэж оруулж ирсэн юм.

Хоёрдугаарт энэ төрийн санд байлгах нь үнэхээр ач холбогдолтой юм уу энийг тодруулмаар байна.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Гараа өргөөрэй. 6 номер.

Д.Цолмон: ЗГХЭГ Цолмон. Анар гишүүний эхний асуултад хариулъя. Ерөнхийдөө бол энэ хуулийн төсөл дээр бол 34.5 дахь, 34 дүгээр зүйлийн 3-аас 34.8 дугаар хэсэг бол яг энэ байгаль орчны хамгаалал, энэ уурхайн олборлолт, аюулгүйн ажиллагаатай холбоотой заалтууд байгаа.

Тэгэхээр ерөнхийдөө бол энэ үндсэндээ энэ үйл ажиллагаанд 3 төрлийн байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явагдаж байгаа юм.

Нэгдүгээрт нь ерөнхийдөө уурхайн бид нар яг энэ оруулж ирээд байгаа уурхайн хаалт буюу нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд зориулаад энэ хөрөнгө оруулагчийн энэ үүргийн гүйцэтгэлийн баталгаа болгож энэ төрийн дансанд мөнгөн хөрөнгө байр шуулах асуудлыг энэ хуульд тусгаж өгчхөөд байгаа юм. Энэ зорилго нь бол таны дурдаад байгаа

Байгаль орчны тухай хууль болон Байгаль орчны үнэлгээний тухай хуульд заасан тэр байгальд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нийтлэг хүлээдэг байгаль орчныг нөхөн сэргээх хамгаалах үүрэгт тэр байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухайн зардлын тухайн жилийн зардлын 50 хувийг төвлөрүүлдэг. Энэ сангаас тусдаа асуудал юм аа.

Тийм учраас энэ бол зөвхөн тэр энэ аюултай стратегийн бүтээгдэхүүнийг олборлох явцадаа энэ тусдаа ийм хяналтад байдаг энэ бүтээгдэхүүнийг энэ олон улсын энэ байгууллагаас гаргасан заавар дүрэм журам энэ зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх нь бол энэ Засгийн газрын тэр ОУБ-ын хүлээсэн нэг үүрэг байгаад байгаа юм. Энийг бол харин тэр төрийн дансанд байлгах уу эсвэл энэ олон улсын энэ банк санхүүгийн байгууллагын баталгаа хэлбэрээр авч болох уу гэдэг асуудлыг бид судалж байгаа. Тэр осолтой холбоотой. Тэр Цөмийн энергийн тухай хуулийн одоогоор үйлчилж байгаа 28.9 дээр байгаад байгаа осол гарсан гэнэтийн осол гарсан үед баталгаа болгож энэ төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулах энэ зохицуулалт хүчин төгөлдөр үйлчилж байгаа юм. Энэ бол ерөнхийдөө бол тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаандаа осол гарвал яах вэ. Үйл ажиллагаанд нь осол гарах юм бол бэлэн байдлыг хангаж энэ үүргээ гүйцэтгэх баталгаа болгож энэ мөнгөн хөрөнгө байршуулж байгаа асуудал байгаа.

Тэгэхээр энийг бол тусад нь салгаж авч энэ үүргийн гүйцэтгэлүүдийг тус тусад нь авч л үзэх нь зөв гэж үзээд байгаа юм. Тэрийг уялдуулна гэхээр зэрэг тусдаа зориулалттай, тусдаа үүргийн биелэлтийг хангуулахаар ийм сангуудад мөнгөн хөрөнгө байршуулж байгаа учраас тусад нь л ойлгох ийм хэрэгцээ шаардлага үүсээд байгаа юм аа.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулъя Анар гишүүн.

Ч.Анар: Гурван тусдаа чиг үүрэг бүхий заалт байгаа гэдгийг би ойлгосон тэрийг та тайлбарлаад байна. Миний асууж байгаа асуулт нь өөр байхгүй юу. Яагаад энэ төрийн дансанд энэ 28.9 дээр тавигдсан 900 мянган доллар байгаа юм байна лээ шүү дээ. Яг энэн шиг энэ маань өөрөө 2019 оноос хойш байршигчсан энэн шиг дахиад дансандаа байршаад улсад өгөөжгүй ийм мөнгө байрших гээд байна. Энийг яаж зохицуулах юм бэ? Яагаад төрийн дансанд юм бэ? Төрийн тусгай данс ч юм уу илүү уян хатан байлгаж болоогүй юм уу гэдгийг асуугаад байгаа юм.

Хоёрдугаарт нь тэр хаалтын дараах гэдгийг ойлгож байгаа. Явцын биш. Тэр хаалтын дараа зарцуулах энэ нөхөн сэргээлтийн хөрөнгийг яагаад Засгийн газрын журмаар зохицуулна гэж заачихсан байгаа юм бэ? Тэгээд энэ чинь өөрөө Их Хурлаар биш энэ Засгийн газар энийг яаж л бол яаж зааж болно шүү дээ. Тэгэхээр энэ нь ямар учраас ингэж орж ирсэн юм бэ л гэдгийг асуугаад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Ер нь Цөмийн энергийн хууль бол нөгөө 2009 оноос хойш яг ингээд өөрчлөлт ороогүй учраас ороогүй гэх нь хаашаа юм 2015 онд нэг хэд орсон байна. Учраас ингээд бусад хуулиудтай энэ ерөөсөө нийцээгүй байгаа байхгүй юу. Жишээ нь саяын тэр нөгөө эрсдэлийн санг бий болгох тэр мөнгөн хөрөнгө байршуулах чинь уул уурхайн салбарт угаасаа л хийгддэг ажил. Гэтэл Цөмийн энергийн хуулиар дээр зохицуулагдаагүй байсан харилцаа. Тэгэхээр тэнд нь мөнгөн хөрөнгө байршуулаад тэр ямар зорилготой юм бэ гэхээр эрсдэл үүсвэл дээрээс нь нөгөө уурхайгаа хаахдаа нөхөн сэргээхгүй хаяад яваад өгчихвөл түүнээгээр нь менежментийн компаниуд гэрээ хийлгээд түүнийг нөхөн сэргээх ажлыг нь хийлгэдэг тиймээ? Тэгэхээр наадхыг чинь Засгийн газар энийг чинь ингээд нөхөн сэргээх ажлыг нь хийлгэе ингэж байршуулъя гэдгийг нь

шийдэхгүйгээр энэ мөнгийг шууд Их Хурлаар тэр зарцуулалт болгоныг нь шийдээд явна гэж байхгүй. Энэ чинь бол хаалтын л асуудал болохоос өмнө захиран зарцуулах ойлголт огт байхгүй шүү дээ.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Учрал сайдын тайлбарыг маш сайн ойлгож байгаа юм. Энэ бол ерөөсөө маш зөв зүйтэй заалт. Би нөгөө энэ заалтыг нь шүүмжлээгүй байгаа юм. Энэ яагаад энэ нөгөө санд байршуулахдаа арай өгөөжтэй байршуулмаар байна. Тэрийг асуугаад байгаа байхгүй юу?

Хоёрдугаарт энэ нөгөө журам маань өөрөө гаднын хөрөнгө оруулалт одоо бид нарын түргэвчилсэн яаралтайгаар оруулж ирж байгаа чинь энэ эцсийн үр дүнтэй энэ уран талтайгаа гэрээгээ л байгуулах гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ журмаар зохицуулагдчихаар гаднын хөрөнгө оруулагч чинь өөрөө энийг эрсдэлтэй заалт байна гэж ирээд бид нар үр дүндээ хүрэхгүй байх эрсдэлтэй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ журам маань өөрөө эргэлзээтэй байна л гэдэг юмыг асуугаад байгаа юм. Тэрнээс энэ нөгөө энэ тус заалт нь өөрөө хаалтын дараа хаалтын үйлдвэрийг уурхайн ашиглалтын хаалтын дараах нөхөн сэргээлтээ хариуцах баталгаа гэдгийг бол маш сайн ойлгож байгаа.

Г.Тэмүүлэн: 5 номер.

Г.Тэмүүлэн: Анар гишүүний тодруулгад хариулт өгье. Физикийн ухааны доктор Норовын Тэгшибаяр, шинжээч.

Нигерээс өөр газар ийм бэлэн мөнгө байршуулдаг жишээ бол байхгүй ээ. Монгол Улс 2 дахь нь болох гэж байгаа. Тэгэхээр бол олон улсын банкны баталгаа гаргуулаад тэр баталгаа нь бол хэрвээ энэ улсууд энэ төсөл хэрэгжүүлэх энэ чинь зөвхөн ганц Ронад зориулсан биш шүү дээ. Төсөл хэрэгжүүлэгч компани аливаа нэгэн

байдлаар үүргээ биелүүлэхгүй гарах юм бол тэр олон улсын банкных нь баталгаагаар Монгол Улс өөр хүмүүсээр хийлгэдэг ч юм уу ийм байхгүй бол Монголын төрийн дансанд орчих юм бол тэд нар гараад явчих юм бол Монгол төр тэрний асуудлыг хариуцна. Магадгүй төсвийн цоорхой нөхчих ийм эрсдэл байгаа учраас хэрвээ Улсын Их Хурал шийддэг бол энэ шийдэхдээ олон улсын I дүгээр зэрэглэлийн банкаар баталгаа гаргуулаад л явах нь зүйтэй л гэсэн бодол байна.

Г.Тэмүүлэн: Алтаниагай гишүүн асуулт асууя.

Н.Алтаниагай: Бүгдээрэнд нь өдрийн мэнд хүргэе.

Зарчмын хувьд энэ Цөмийн энергийн тухай хуулийг дэмжиж байгаа яаралтай горимоор орж ирсэн. Тэгээд энэ өөрөө Монгол Улсын эдийн засагт дам нөлөөлөл үзүүлэх эдийн засгийг солонгоруулах гээд маш олон талын ач холбогдолтой. Үүнээс гадна яг энэ одоо төсөл хэрэгжсэнээрээ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд нөлөөлөл үзүүлэх эрсдэл ямар байгаа вэ? Энэ дээр үнэлгээ хийгдсэн үү? Энэ бол өөрөө нөгөө стратегийн бүтээгдэхүүн учраас энэ дээр I дүгээрт маш болгоомжтой хандах ёстой гэж.

Хоёрдугаарт энэ тухайн олборлолт хийгдэх бүс нутгийн байгаль орчинд ямар яг сөрөг нөлөөлөл үзүүлэх вэ? Мэдээж энэ нөгөө маш олон тэмцэгч нар гараад ирдэг энэ сургаар удахгүй тэр жагсаал цуглаанаа хийх байх. Тэгээд нөгөө шар нунтаг чинь хамгийн аюултай гээд энийгээ яриад нэхээд удахгүй талбай дээр гараад ирэх байх. Тэгээд энэ хог хаягдлыг яг хаана булшилж устгах вэ?

Бид нар ашгаас илүү энэ аюулгүй байдлаа байгаль орчиндоо бас илт хандах энэ зүйлүүдээ түлхүү ярьж иргэддээ болон нийгэмдээ ойлголтоо сайн өгөхгүй бол эрсдэлтэй шүү. Болсон.

Г.Тэмүүлэн: Хэн хариулах уу, асуултад? Гараа өргөөрэй. Тэгээд урагшаагаа сэлгээд суучих. 8 номер.

Э.Нямдаваа: Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Нямдаваа, гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсад хаягдлын менежментийг хийх дүрэм журмуудыг бол олон улсын атомын энергийн агентлагийн стандартад нийцүүлээд батлан гаргасан байгаа. Цөмийн энергийн комиссоос хүдрийн олборлолт боловсруулалтаас үүсэх цацраг идэвхт хаягдлын менежментийн дүрмийг батлан гаргасан байгаа. Тэгээд энэ дүрмийн дагуу бол тухайн төслийн талбай дээр нь яг тогтвортой геологийн нөхцөл орчин энэ тэрийг нь судалж байгаад төслийн талбай дээр одоо аюулгүй гүйцэтгэх ийм зохицуулалттай байгаа. Нэг жилд бол тухайн зөрчлөөс 250 тонн цацраг идэвхт хаягдал гарна гэсэн тооцоотой байгаа. Тэгээд үүнийг бол энэ олон улсын атомын агентлаг болон энэ Монгол Улсын үндэсний дүрэм журмын дагуу төслийн талбай дээрээ аюулгүй менежмент хийх, ландфилл хийх ёстой гэсэн ийм шаардлагыг тавьж байгаа.

Тэгээд тухайн одоо бас энэ хаалт буюу энэ хаягдлын менежмент хийх нөхөн сэргээхтэй холбоотой энэ санхүүгийн баталгааг нь хангах энэ зохицуулалтыг бол хуулийн төсөл дээрээ оруулж ирсэн байгаа. Энийг блд олон улсын атомын энерги агентлагийн зөвлөмжийн дагуу ер нь Засгийн газар нь бол энэ баталгааг бий болгосон байх ёстой. Энэ зохицуулалтыг бий болгосон байх ёстой гэсэн шаардлагууд тавигдсан байдаг. Үүний дагуу ерөнхийдөө төрийн дансанд байршуулна гэсэн энэ хуулийн заалтыг оруулж ирж байгаа.

Гэхдээ энэ нь болохлоор тусгай байгаль орчныг нөхөн сэргээх тусгай данс гэсэн ийм нэртэйгээр орох боломжтой байгаа гэж үзэж байна.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

М.Батсүмбэрэл: Нэгдүгээрт, нь тэр нөхөн сэргээлтийн зардал гээд байгаа юуг сая Анар гишүүн асуучихсан. Тэрийг нэмээд тодруулаадахъя. Нөгөө түрээсэнд байршуулчихдаг ямар валютаар байршуулах гэж байгаа вэ? Ханиийн алдагдалд гарах вий. Эс үгүй бол төр засаг өөр болж байгаад нөгөө байршуулсан мөнгөө хэрэглэх вий дээ. Тэгээд энэ уурхайгаа хаах болсон чинь мөнгөгүй болчихсон сууж байх вий. Энэний эрсдэлийг яаж хааж өгч байгаа юм? Нэг дэх асуулт.

Хоёр дахь асуулт ба ажлын хэсгийн гишүүн Баярхүү доктороос асууя.

Чухам одоо энэ Монгол, Франц 2 энэ том хэмжээний төсөлд орох гэж байна. Гадаад улс орнууд энийг ажиглаж байгаа. Ямаршуу дүгнэлтүүд явж байна? Монгол, Францын хамтын ажиллагаа өнөөдөр ямар байдалтай явж байна? Энэ том төсөл хэрэгжсэнээр гарах 2 улсын хоорондын хамтын ажиллагааны нөхцөл ямар байдлаар өөрчлөгдөх вэ? Энэ олон улсад бас яаж нөлөө үзүүлэх вэ? Та мэргэжлийн хүний хувьд хэрхэн дүгнэж байна вэ? Үүнийг тойрсон асуудал бол олон нийт хүлээж байгаа шүү дээ. Саяын Алтаниагай гишүүний хэлдэгчлэн уранаас үүдэлтэйгээр хонь мал өөр өөр гардаг ч бололтой юм яриад байдаг. Ард нь тэр олон улсын харилцааны асуудал яриад байдаг. Энэ дээр мэргэжлийн судлаач хүний хувьд энэ Байнгын хороонд мэдээлэл тайлбар өгөх нь зүйтэй байх гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: 2 асуулт байна асуултад хариулъя. 9 номер Баярхүү доктор. 9 номер.

Г.Тэмүүлэн: Энэ түрүүний эхнийх нь асуултыг би мэдэхгүй юм байна.

Хоёрдугаар асуулт нь Тэр Монгол, Францын харилцаанд ямар хамаатай вэ гэж. Тэгэхлээр ер нь Монгол, Францын харилцааны түүхийг хараад байхаар зэрэг Франц, Монгол Улсын энэ тусгаар тогтнол, хөгжил дэвшил, ардчилал, шинэчлэл гээд бүх үйлсэд нь бол их өөдрөг эергээр найрсгаар хандаж ирсэн улс байдаг юм аа. Тэгээд Монгол Улс өнөөдрийн байдлаар 8 улстай стратегийн түншлэлийн харилцаа тогтоочихсон байгаа.

Тэгэхдээ энэ 8 улс бол энэ түншлэлд хүрэхийн тулд их олон дамжлага дамжаад хүрээд ирсэн. Одоо бол 17 улс субъекттэй бид түншлэлийн харилцаа байгаагаас тэгш эрхтэй түншлэл хамтын ажиллагааны түншлэл, харилцан нөхсөн түншлэл, сайн хөршийн түншлэл, иж бүрэн түншлэл, өргөтгөсөн иж бүрэн түншлэл өргөн хүрээтэй түншлэл гээд. Ингээд стратегийн түншлэл. Гэтэл Франц бол 2022 онд Ерөнхийлөгчийн айлчлалын үед бол энэ олон түншлэлийн ямар ч шатыг дамжихгүйгээр шууд Монгол Улстай онцгой эрхт түншлэлийн харилцааг тогтоочихсон. Тэгэхээр бол энэ манай гадаад бодлогын том ялалт болсон.

Хоёр улсын Ерөнхийлөгч харилцан айлчилсны дүнд бол Франц манайхыг онцгой эрхтэй түнш гэж үзсэн. Монгол бол чухал гуравдагч хөрш Европ дахь гэж. Тэгээд хоёулаа нийлээд онцгой эрхт түншлэлийн харилцаа буюу *превлекжит партнёршип* гэж. Тэгэхээр бол энэ том харилцааг бол бид нар нандигнаж хайрлаж Францаас өгч байгаа энэ өгөөмөр сэтгэлийг энэ цаг үе, энэ минутад яг одоо л ашиглаж амжихгүй бол энэ мөнх биш ээ.

Тэгэхээр бидний энэ Монголын энэ ардчиллын 34 жилийн ардчилал шинэчлэл, энэ хүний эрх, эрх чөлөө энэ тэр нь бол тэр өөртөө анхаарал татдаг тэр экзотик үеэ өнгөрөөгөөд өнөөдөр манайд бодитой ямар сонирхол орж ирэх юм бэ гэхээр зэрэг Франц бол ардчилал шинэчлэл

хамаг юм чинь сайн байна. Францын бодитой сонирхол бол энэ том хөрөнгө оруулалт. Энэ стратегийн том хөрөнгө оруулалтад Франц орж ирж Монголын баялгийг хамтран ашиглах шар нунтаг үйлдвэрлэх энэ болж байна гэдэг нь бол бидэнд ойлгогдож байгаа, бидэнд харагдаж байгаа.

Тийм учраас энэ алтан цаг үеийг бид ашиглаад авчих хэрэгтэй гэсэн ийм байр суурь тай байна аа. Олон улсын харилцаанд Монгол, Францын энэ хамтын ажиллагаа ямар нөлөөтэй вэ гэж. Үнэхээр Монгол, Франц 2 энэ цөмийн эрчим хүчний салбарт хамтран ажиллаж байхад бол энийг бусниулъя, нураая, хөндлөнгөөс оролцъё, эс үгүй бол эрх ашгийг нь хуваалцъя, мөнгийг нь хуваалцъя гэсэн ийм гадаад улс орон гарч ирээгүй ээ. Франц бол дэлхий дээр хүлээн зөвшөөрөгдсөн цөмийн том гүрэн. Аюулгүйн зөвлөлийн байнгын нэг гишүүн.

Тэгээд Монголтой өнөөдөр энэ салбарт хамтран ажиллаж байгаа нь бол Францын хувьд хамгийн зөв зүйтэй. Европын холбооны хамгийн том чирэгч. Тэгээд Монгол, Францын энэ хамтын ажиллагаа энэ хөрөнгө оруулалт цаашаа дардан замаар орох юм бол Францын жишгээр Монгол гадаадын Европын маш олон улс оронд итгэгдээд энэ цаашаа явах юм байгаа юм. Тэгэхээр бол.

Г.Тэмүүлэн: Учрал сайд нэмээд хариулъя.

Н.Учрал: Тийм гишүүд асууж байна аа. Ер нь бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийн 9.10 дээр энэ үүргээ биелүүлэх баталгаа болгоод шаардагдах зардлынхаа 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тусгай дансанд байршуулна гээд ингээд заачихсан байдаг энийг хэрэгжүүлдэг.

Тэгэхээр цөмийн энергийн хууль бол энийг дагалдуулаад ингээд зохицуулаад ороод ирсэн. Түрүүн Анар гишүүн

асуугаад байсан. Мөнгөн хөрөнгийн хэмжээг жил бүр олборлох ураны эслийн хэмжээг үндэслэнэ. Төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэнэ гэхээр нөгөө мөнгөн хөрөнгийн байршуулах дансны чинь хэмжээ ямар байх вэ гэдэг нь нөгөө ураны ислийн үнээс шалтгаалах гээд байхгүй юу. 2007 онд 10 доллар байсан ураны үнэ чинь өнөөдөр 83 доллар болчихоод байна шүү дээ. Тэгээд тэрийг чинь хэдэн төгрөгийг та нар тэр баталгаа болгож дансанд хийх юм бэ гэдгийг Ураны үнэ 3 доллар өслөө гээд л Их Хуралд барьж ороод ирээд байх юм уу л гэдэг л ийм л санаатай л заалт юм байна. Тэгэхдээ Их Хурал дээр ажлын хэсэг ажиллачхаж болох байх.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Ер нь юу билээ улсын төсөв ярьж байхад ч дундуур нь хууль орж ирдэггүй гэсэн. Нэг тийм юм байдаг билүү үгүй билүү. Гэхдээ яаралтай горимоор болохоор болдог байх тийм ээ. Тэгээд энэ улсын төсөв ярих үед энэ хүмүүсийн анхаарлыг сарниулах маягтай ингэж хандаж байна уу? Үнэхээр тийм хойшлуулжгүй юм байгаа юм уу? Тэгээд өнөө маргаашгүй ашиглалтад орчих уу? Яг ямар байгаа юм. Яг ямар шатандаа байгаа юм. Юу нь саатаад ингэчихсэн юм бол. Тэрийг нэг сонирхчихмоор байх юм. Тэгээд ганц нэг улсууд энэ хэвлэл мэдээллээр нэг пи арын шинж чанартай. Бид нар эрчим хүчээ солонгоруулчихлаа. Энэ тэр гээд юу юугүй одоо энэ зүгээр жирийн л юу байх гэж бодоод байгаа шүү дээ тэ? Бүтээгдэхүүн гэж бодож байгаа юу? Ямар байгаа эсвэл онцгой юм уу? Засгийн газар юу гэж үзэж байгаа юм. Өнөө маргаашгүй АЦС барьчих гээд байгаа юм уу? Бид нар чинь цөмийн гүрэн болчих юм уу? Тийм амбицтай яваад байгаа юм уу? Яах вэ Франц улсыг бол мэдэж байгаа. Тэртээ тэргүй Герман бол цөмийн эрчим хүчийг бол хэрэглэхээ больё гэхихсэн байгаа шүү дээ Европт бол. Франц нь болохоор энэ АЦС-аа хэрэглэж үнэхээр хямдхан эрчим хүч үйлчилж,

үйлдвэрлэж, өрсөлдөх хүч чадвартай байя л гэж байгаа шүү дээ. Тэгээд Африкт байдаг энэ эх үүсвэрээ алдчихсан гэж ойлгож байгаа. Манайх энэ боломжийг ашиглаад энэ зах зээл дээр орох зөв өө. Гуравдагч орны тэр хөрөнгө оруулалт энэ тэрийг дэмжиж байна аа. Бас нэг ийм юм байна аа. Энэ энгийн иргэд хувьцаа энэ тэрийг чинь худалдаж аваад эзэмших юм уу эсвэл Засгийн газар нь энэ хувьцааг нь давуу эрхтэй хувьцаагаар бариад явах юм уу? Нэгэнт хэлэлцэж байгаа болохоор би асууж байна л даа. Энэ хууль дээр оруулж ирж байх шиг байна.

Нөгөө талаар бид нар бас энэ уран чинь нэг бодлын зүгээр энгийн зүйлд хэрэглэдэг цаашидаа бол нэг эмнэлгийн тоног төхөөрөмж хийж болдог ашигладаг, нөгөө талаараа үй олноор хөнөөх зэвсэг болгож болдог ийм л бүтээгдэхүүн байх шиг байна л даа. Тэгэхээр манай Монголоос гарч байгаа энэ тэр нунтгаа ийм ийм зүйлд ашиглаж болно, ийм зүйлд ашиглаж болохгүй гэсэн ийм юм байх ёстой юу эсвэл хамаагүй байдаг юм уу ямар байдаг юм бол? Өмнө нь одоо бас Монгол Улсад уран олборлож байсан гэж ойлгоод байгаа шүү дээ тэр Мардайд. Энэ талаар ямар туршлага байдаг юм бэ? Хамгийн гол юм бид нар тэр цөмийн хаягдал энд тэнд аваачиж булдаг барьдаг тэр нь энэ орон нутагт бэлчээр ус унданд буруугаар нөлөөлдөг барьдаг энэ юмыг тийм биш гэдгийг ард олондоо сайн ойлгуулах хэрэгтэй л дээ. Нэг ийм хэдэн асуулт байна аа.

Г.Тэмүүлэн: Учрал сайд асуултад хариулъя.

Н.Учрал: Яах вэ түрүүн би хэлсэн 27 жил ажлын хэсэг байгуулж анхааралтай ажигласаар байтал Казахстан гэдэг улс олборлолтоороо дэлхийд тэргүүлээд хэдхэн сарын өмнө АЦС-тай болох уу гээд ард нийтийн санал асуулга явуулаад дэмжчихлээ. Тэгэхээр ер нь бол бид бид нар нэг ийм хөгжлөөс хоцорсон байдалтай тэгээд нэг улс төрждөг хийрхдэг энэ байдлаасаа салж

энэ хамтарсан Засгийн газар байгуулсны ач холбогдлоо л гаргах хэрэгтэй. Тэгээд хурдтай хөгжлийн төлөө зориг гаргая гэсэн. Тэгээд улс төрийн намууд зөвшилцөөд энэ 14 мега төслийнхөө дотор энэ ураны төслийг бол оруулсан.

Тийм ч учраас бол яг энэ цаг үе нь мөн үү гэвэл мөн. Дээрээс нь сая Ганбат гишүүн хэлж байна. Нөгөө анхаарал сарниулаад гэж хамгийн бараг их анхааралтай ажиглаж байгаа цаг нь бол яг одоо байх шиг байна. Төсөв хэлэлцэж байгаа дээрээс нь цаг улирлын хувьд ч гэсэн их хамгийн их анхаарч байна. Мааи анхаарлын төвд байгаа сэдэв. Иргэд ч гэсэн анхаарах ёстой сэдвийн нэг гэв мөн үү гэвэл мөн юм аа.

Тийм учраас бол бид цаг алдах хэрэггүй. Ирэх жил ураны хэрэглээ 120 мянган тоннд хүрэх гэж байна. Гэтэл бид нийлүүлэх нь бол дэлхий дахин нэгдээд нийлүүлэх нь 80 мянга л юм билээ. Тэгэхээр ерөөсөө үнэ ч бай эрэлт ч бай үнэ цэн ч бай бол өсөх нь бол дамжиггүй болчихсон. Тэгэхээр бид нар энэ дэлхийн зах зээлээс хоцорч болохгүй урагшилъя. Цаашилаад бол мэдээж Монгол Улс АЦС-тай болох судалгаа хийе. Бүх талын эрэл хайгуулаа хийе. Ингээд урагшилъя гэсэн ийм бол бодолтой байгаа. Энэ хууль батлагдсанаараа бол нөгөө хэлэлцээ хийх эрх зүйн орчин бүрдэнэ. Түрүүн хэлсэн тэр 10 хувь байна уу одоогийн хуулиар бол нөгөө төрийн эзэмшлийн 34 бол шууд хуримтлалын сан руу л орно гэсэн зохицуулалттай. Гэхдээ ноогдол ашиг өгөх үү өгөхгүй юу гэдэг нь эргэлзээтэй шүү дээ. Анх өмнө нь бид нар нэг хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан түүхтэй биз дээ. Тэгээд тэр одоо хөрөнгө оруулалтын гэрээний ноогдол ашиг чинь 37 оноос гэдэг болчихсон явж байна шүү дээ.

Гэтэл яг энэ дээр ингээд ноогдол ашиг авна гээд өөдрөггөөр тооцоод ордог. Төр хариуцлага хүлээдэг, өртэй болдог тэгээд санхүүгийн хариуцлага хүлээдэг энэ нь бүтэхгүй нь ээ. Тийм учраас ерөөсөө тэр 10 хувийнхаа давуу эрхийн

хувьцаагаа хуримтлалын сан руугаа аваад тэгээд тэгээд гэр бүл, эрүүл мэнд, боловсрол, орон сууцдаа зарцуулдаг. Бусад АМНАТ-аа өсгөх юм бол АМНАТ-ын 65 хувиа Ирээдүйн өв санд хийгээд, үлдсэнээ орон нутаг, Тогтворжуулалтын сан дээрээс нь ер нь бол төсөл хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулагч тал бол орон нутгийн хөгжлийн санд чинь энэ АМНАТ-ын тодорхой хувь орох хэдий ч тэр төсөл хэрэгжих гээд байгаа Дорноговь аймгийн тэр Улаанбадрах сум тэр орчимд бол 1 сая долларыг жил болгон нийгмийн хариуцлагад өгнө гэдэг ийм хэлэлцээр яригдсан.

Г.Тэмүүлэн: 3 номер.

Л.Жаргалсайхан: Монгол Улс манайхаас гарах энэ ураны шар нунтаг гэдэг бол яг нөгөө өндөр идэвхтэй тэр цөмийн зэвсэг ч юм уу энд хэрэглэдэг тийм АЦС-д хэрэглэдэг яг тэр идэвхтэй бүтээгдэхүүн бол биш. Тэрний өмнөх одоо түүхий эд л гэсэн үг шүү дээ. Тэгэхээр байгаль дээр оришиж байгаа ураны ислийг бид нар ялгаж аваад ингээд юу шар нунтаг гэсэн ислийн хэлбэрт оруулаад тэгээд явуулж байгаа. Тэгэхээр энэ бол цаашидаа нөгөө 6 фторт уран болгоод, тэгээд цаашиа баяжуулаад, яг нөгөө уран 235 гээд ийм болгоод ингээд явах ийм боловсруулалт орсны дараа л тэр нөгөө яг одоо нөгөө цөмийн түлш болох уу, бөмбөг болох уу гэдэг чинь шийдэгдэнэ.

Тэгэхээр энэ бол бид нарынх бол зөвхөн түүхий эд юм.

Г.Тэмүүлэн: 7 номер нэмж хариулах юм уу? 7 номер.

Э.Нямдаваа: Монгол Улс 1972 онд цөмийн зэвсэг үйлдвэрлүүлэх энэ гэрээг олон улсын атомын агентлагтай хийсэн байдаг. Тэгээд энэ гэрээний дагуу бас Монгол Улсад ашиглаж буй бага хэмжээний материалын тоо хэмжээг олон улсын атомын агентлагт мэдээлснээр ирсэн байгаа. Тэгэхлээр Монгол Улс бол энэ зүүний материалыг ер

нь энхийн зорилгоор ашиглах ийм үүрэг хүлээдэг байгаа. Тэгэхлээр шар нунтаг энэ уран исэл маань бас өөрөө энэ цөмийн бодис ч гэсэн энэ нэр томъёоны тодорхойлолтод оруулсан байгаа. Тэгээд Бадрах Энержи компанийн хувьд 10.4 тонн уран агуулсан. 27.5 тонн энэ амманидын урануудыг гарган авсан байгаа. Тэгэхээр энэний бас цөмийн бодис, бодисыг ашиглах, эзэмших зөвшөөрлийг Цөмийн энергийн комиссоос олгосон байгаа. Тэгээд энэ тоон мэдээлэл баримтыг олон улсын агентлагт хүргүүлсэн байгаа.

Тэгэхээр хамгийн гол нь энхийн зорилгоор ашиглах ёстой. Мөн энхийн зорилгоор ашиглах энэ улс.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Та нөхдүүд наад юм хумаа ойлгоотоо сайн судлаарай. Тийм манайд анх удаагаа явж байгаа болохоор мэдээж хэрэг юу байгаа байх аа. Тэр нарийн судлаагүй бариагүй юмнууд байдаг биз.

Гэхдээ яг хэзээ энэ шар нунтагаа зарах гээд байгаа юм? Хэзээ гэрээ хийгдээд орчих гээд байгаа юм? Тийм нэг график энэ тэр байна уу? Ингээд төлөвлөчихсөн. Яг өнөө маргаашгүй орох гээд байна уу эсвэл тэгээд явж байгаад жилийн дараа ч орох юм уу эсвэл ахиад 10 жил рүү үргэлжлэх юм уу яг ямар байдалтай байгаа юм?

Г.Тэмүүлэн: Нэг номер.

Д.Далайжаргал: Далайжаргал Мон-Атом байна. Энэ өөрөө графиктай цаг хугацаатай бизнес юм. 2024 онд бид нар багтаагаад хөрөнгө оруулалтын гэрээгээ байгуулчихвал 4 жилийн хугацаанд буюу 2028 оныг хүртэл Францын Рона групп нь нь ярьж байна. Үйлдвэрийнхээ дэд бүтцийг 4 жилийн хооронд барьж гүйцээх юм. Жилд 2500 тонн уран гаргадаг үйлдвэр гэдэг бол

дэлхийд эхний 5-д орох тийм үйлдвэр болох учраас энэ 4 жилийн хугацаанд энэ үйлдвэрийг барьж хийх юм аа. Тэгэхээр Франц улс бол өнөөдөр Нигер, Канад, Казакстан гэсэн 3 улсаас уран олборлож байсан. Нигерт та бүхэн мэдэх байх өнгөрсөн жил төрийн эргэлт хийгээд Нигер Францын Засгийн газрыг хөөж гаргасан байгаа. Одоо бол Казахстаны орд ойрын 3 жил дууссан. Тэгэхээр дараагийн 38 жил буюу тогтвортой уран олборлох ганц улс нь Монгол Улс болох юм. Та тэр Мардайн тухай асуудал ярьсан. Мардайд 1985-1990 оны хооронд Оросын холбооны тухайн үед ЗХУ 500 тонн ураныг олборлоод тэгээд 90-ээд он гараад тэгээд гараад явсан. Тэрний дараа гадаадын олон компаниуд тэр лицензийг нь эзэмшиж байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Номтойбаяр гишүүн асуулт асууя.

Н.Номтойбаяр: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгээд манайх чинь их ядуу улс шүү дээ. Нэг түүхий нүүрс экспортлоод дэлхийн энэ геополитик эдийн засгийн интеграцид ч орж чаддаггүй. Тэгээд энэ нэг хөдөлснөөрөө ороод эхлэх нэг суурь тавигдах байх. Сүүлийн хориод жил. Тэгээд урьд нь чинь бас ураны лиценз нэг компанид олгосон. Төр нь өөрөө хулхидаад олон улсын шүүх дээр 70 сая долларын нөхөн төлбөрт ороод тэрийгээ төлж байсан. Эргээд энэ урантай холбоотой асуудлын үүх түүхийг сөхөхөөр ичмээр л олон зүйлүүд бий. Тэгэхдээ мэдэхгүй зүйлүүд их байгаад байна. Адаглаад энэ цөмийн энерги урантай холбоотой энэ технологи олборлолтын горимууд энийг мэддэг Их Хурлын гишүүд лав л лав байхгүй байх. Ер нь Монголд боловсон хүчний бодлогын хувьд хэр бэлтгэгдсэн юм байгаа юм. Нэг цөөн хэдэн эрдэмтэн судлаачид л байгаад байдаг. Түүний төлөөлөл энд сууж байх шиг байна. Тэгэхээр цаашидаа энэ тал дээр нэлээн урт удаан хугацааны стратеги чухал салбар гэж харж байгаа бол бид бас боловсон хүчний бодлогоо бодох л ёстой байх. Энэ хосолмол ашигт малтмал

байгаа тохиолдолд яадаг юм бол. Энэ Уур уурхайн яамныхан байгаа байх тэ? Ажлын хэсэгт. Жишээлбэл Дорнодод яадаг вэ гэхээр нүүрсний нөгөө лиг найт нүүрсний орд газар их байдаг тэгээд дандаа урантай холбоотой. Хоёроос 3 хувийн ураны агууламжтай нүүрсний орд газрууд байгаад байдаг. Тэгэхээр энэ тохиолдолд энэ эрх зүйн орчин маань яаж явах билээ? Нөгөө байгуулах гэрээ хэлэлцээрүүд яаж явах вэ? Ер нь ураны байгалийн тогтоц дээрээ бүтэц нь ер нь чухам яаж байгаад байдаг юм? Зөвхөн дан уранаараа байхгүй л байж таарах. Энэ хууль дээр нэг ийм юм байгаад байна. Төрийн эзэмшлийн хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болох гээд. Тэгснээ доор нь болохоор ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг тухайн одоо, ордын онцлог, ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшинийг харгалзаж Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоох гээд. Тэгэхээр эхнийхтэйгээ харьцуулаад үзэх юм бол 2 дахь нь Засгийн газрын зөвхөн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоох гэдэг тийм ойлголт үүсээд байна. Тэгэхээр энэ нөгөө үг зүй утга тайлбарын хувьд алдаа гараад байна уу эсвэл үнэхээр энэ нөөц ашигласны төлбөрийг тогтоохдоо Засгийн газрын Улсын Их Хуралд мэдүүлснээр шууд тогтоох юм уу, эсвэл нөгөө зарчмаараа Улсын Их Хурал өөрөөр тогтоож болох юм уу? Энийгээ Учрал сайд тодорхой болгоод өгчихсөн нь дээр. Тэгэхгүй бол маргааш энэ чинь хэзээ билээ? Нөгөөдрийн чуулган дээр орох билүү, маргааш орох билүү?

Танилцуулга дээрээ ч гэсэн энэ ураны энэ хэлэлцээр ямар түвшинд олборлолттой яах юм? Сая энэ мэргэжлийн хүн тайлбар хэлж байна л даа. Тэгээд сая мэргэжлийн хүнээс сонсоод л ер нь нэг ойлголт аваад байна шүү дээ. Нөгөө анхан шатны гэсэн үү? Тэр түвшинд л гээд. Тэгэхээр танилцуулга дээрээ энийгээ нэлээн ярьсан нь зөв байх. Энэ ноднин билүү дээ уржнан, ноднин

байх энэ Хархоринд ОХУ нэг АЦС-ын ТЭЗҮ боловсруулчихлаа эхлэхэд бэлэн болчихлоо л гээд л. Нөгөө түрүүн Учралын хэлдгээр нөгөө гуя дагаж хүзүү гэдэг шиг ер нь энэ асуудал мэдээж хөндөгдөж л таараа. Тэгэхээр яг энэ тал дээр Монгол төрийн аюулгүй байдал.

Г.Тэмүүлэн: Нэг минут нэмж өгье.

Н.Номтойбаяр: Үзэл баримтлал, баримтлах чиг баримжаа, зарчим нь юу байдаг юм бол? Ер нь энэ асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл авч хэлэлцэж байсан юм болов уу, үгүй юм болов уу? Бид нарт энэ талаар ямар ч ойлголт мэдээлэл алга. Тэгэхээр энэ чинь шууд нөгөө хөрш залгаа хил залгаа улс оронтой асуудал яриад байна шүү дээ. Оросын элчин сайд чинь саяхан нэг хэвлэлдээ өөрөө албан ёсны ярилцлага өгчихсөн байсан даа. Тэгэхээр энэ харгалзаж үзэх хэд хэдэн юмнууд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ томьёоллын хувьд яаж өөрчлөлт орох юм энэ хосолмол металл нь яаж явах гээд байгаа юм. Боловсон хүчин нь яах гээд байгаа юм. Энэ ОХУ-ын яриад байгаа асуудал ер нь ямар түвшиндээ яваад байгаа юм. Мэдээж энэ хуулийн өөрчлөлтийн үр өгөөжийг хүртээд л явна шүү дээ. Тэгээд энэ төрийн.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Хэн бэ нэг номер.

Д.Далайжаргал: Номтойбаяр гишүүний боловсон хүчинтэй холбоотой асуултыг би хариулчихъя. 2003 онд Францын компани хайгуулын лиценз авч эхэлснээс хойш боловсон хүчний хүмүүсийг бэлдэж эхэлсэн байгаа. Сүүлийн 5 жилийн хугацаанд 77 хүнийг 220 удаагийн тэтгэлгээр сургасан. Шинжлэх ухаан технологийн сургуулийг Геологийн сургуультай хамтран тэтгэлэгт хөтөлбөр зарлаад явж байгаа. Ялангуяа Дорноговийн Улаанбадах сумын гаралтай хүүхдүүдийг энэ сургуульд сургаж байгаа. Яг одоо Парист ор

Оранагийн төвд 2 Монгол хүн ажиллаж байна. Франц, Казакстаны том төсөл, Казакстаны Катко гээд тэнд 2 геологич ажиллаж байгаа. Ер нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулчихвал нийтдээ 9 сая орчим долларыг бол яг энэ боловсон хүчинд бэлтгэхээр Францын энэ компани өөрөө бэлтгэчихсэн байгаа. Энэ ярьж байгаа үнэн. Энэ цэвэр геологи гидрохими буюу ийм процесс байдаг юм. Тэр ОХУ-тай асуудал бол 2 жилийн өмнө ШХАБ-ын уулзалтын үеэр ОХУ-ын Ерөнхийлөгч Хархорин шинэ хоттой холбогдуулаад бага оврын АЦС-ыг барья гэдэг саналыг тавьсан. Гэхдээ өнөөдөр ийм ТЭЗҮ эд нар хийчихсэн юм ерөөсөө байхгүй. Хамтран энэ чиглэлээр мэдээлэл солилцъё. Эрдэмтэд солилцож туршилага солилцъё гэсэн ийм шатандаа л явж байгаа. 4 номер.

Г.Жамсрандорж: Тэр Ураны дагалдах байдлын талаар Номтойбаяр гишүүнд хариулъя. Жамсрандорж Мон-Атомын шинжээч. Тэгэхээр манай Монгол орны энэ нүүрсний цэрдийн галавын нүүрсний 3 ордод ураны агуулга харьцангуй өндөр байдаг. Багануурын нүүрсний орд, Адуунчулуун, Өлзийтийн гэсэн 3 нүүрсний ордод хөрсний усны нөлөөгөөр ураны дээд үеүд нь ураны агуулга өндөрссөн байдаг боловч энэ үйлдвэрийн ач холбогдол байдаггүй.

Ийм туршилагууд барууны орнуудад байдаг. Тэгэхээр эдгээр эрчим хүчний нүүрсийг бол зөвхөн шатааж үнсэнд нь уран баяжсаны дараагаар үнсийг нь энэ овоолж нуруулдан уусгах аргаараа ураныг нь баяжуулан гаргах тийм арга замууд байдаг.

Г.Тэмүүлэн: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Энэ Цөмийн энергийн хуулиар бол төр эзэмшлийнхээ 34 хувийг АМНАТ-аар орлуулах бүтээгдэхүүн хуваах төрийн эзэмшлийнхээ хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг

Засгийн газрын өргөн мэдүүлснээр Их Хурал өөрөөр тогтоож болно гэж байгаа юм. Тэгэхээр засаг бол өргөн мэдүүлнэ ээ. Их Хурал яаж тогтоох нь бол Их Хурлын онцгой бүрэн эрх. Гол нь нөгөө Баялгийн сангийнхаа хуулиар төр хэрвээ нөөцийг нь улсын төсвөөр бий болгосон бол 50 хүртэлх хувь, хэрвээ хувийн тэр санхүүжилтээр хийгдсэн бол 34 хүртэлх хувь гэдэг хүрээндээ л АМНАТ-ыг орлуулах асуудал яригдана л гэсэн санаа. Тэрнээс биш Засгийн газрын өргөн мэдүүлснийг Их Хурал яаж тогтоох нь Их Хурлын эрх юм л гэдгийг хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Болсон уу? Би нэг ганц 2 асуулт асуугаадахъя. Цөмийн энергийн тухай хууль дээр энд онцолж хараад байхад гол үндсэндээ яах вэ том өөрчлөлт нь бол АМНАТ руу шилжүүлж байна. Орлуулах тусгай АМНАТ-уудыг нэмэгдүүлж байгаа асуудлууд орж ирж байна. Ашигт малтмалын нөөц төлсөн төлбөр NB20/ 1.² дээр гээд гол үндсэн энэ АМНАТ-ынхаа борлуулалтынхаа үнэлгээг АМНАТ авахтай холбогдуулаад энэ бүтээгдэхүүнийхээ борлуулалтын үнэлгээг хэрхэн тооцох юм бэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр би уншаад үзэхээр үндсэндээ бас нэлээн тийм болхидуу маягаар биччихсэн байгаад байгаа юм. Болхидуу маягаар биччихсэн юм. Энэ нь экспортолсон гэж нэг байгаад байгаа юм. Өөрийн хэрэгцээнд ашигласан гэж нэг байгаад байгаа юм. Тэгээд дотоодод худалдсан гэдэг нэг ийм 3 хэсэг задлаад байгаа байхгүй юу. Тэгэхээр үндсэндээ ашигласан бол нэг өөр үнэлгээтэй байх гээд байгаа юм уу? Дотоод өөрийнхөө хэрэгцээнд ашигласан бол, дотооддоо худалдсан бол нэг өөр үнэлгээтэй байх гээд байгаа юм уу? Экспортолсон бол нэг өөр үнэлгээтэй байх гээд байгаа юм уу? Хилийн наана цаана гэдгээрээ бас нэг арай өөр үнэлгээтэй байх гээд байгаа юм уу? Гэсэн мөртөө яг ингэж нэг ийм сонин байдлаар зааглаж бичсэн мөртөө буцаад доошоогоо очихоороо олон улсын зах зээлийн үнийг баримтална л гэдэг нэг ийм асуудал яах вэ бичээд байгаа юм л даа.

Тэгээд би энэн дээр гайхаад байгаа зүйл нь ер нь яг энэ цацраг идэвхт энэ бодисыг чинь бүтээгдэхүүнийх нь ер нь энэ зах зээлийн үнэлгээг нь яаж тогтоодог юм бэ? Зэс дээр бол яах вэ Лондоны бирж гээд л явчхаж байгаа юм. Энэ төрлийн бүтээгдэхүүн дээр яг яадгийг нь үнэндээ сайн мэдэхгүй юм. Тэгэхээр яг тэнд нь яаж хэн тогтоодог, яаж тогтоодог олон улсын тийм жишиг хүлээн зөвшөөрсөн бирж гэж байдаг юм уу, байдаггүй юм уу?

Үндсэндээ бид бүхэн чинь АМНАТ-тай холбоотой маш их олон маргаанууд үүсэж байгаа шүү дээ. Зэс дээр ч үүсэж байна, Оюу Толгой дээр ч үүсэж байна. Хилийн наана цаана тэгээд ачуулсан, ачуулаагүй, тээврийн зардал шингэсэн, шингээгүй гээд асуудлууд үүсдэг байхгүй юу. Тэгэхээр би үндсэндээ энэ томъёололыг нь бол ямар нэг маргаангүйгээр цэвэр тогтоох ёстой асуудал болчихоод байгаа юм. Энийг цэврээр зөв тогтоохгүй бол магадгүй тэр нэг гэрээнийх нь үнэ рүү шилжих эрсдэл бол байна гэж хараад байгаа юм. Борлуулсан гэрээнийх нь үнэ рүү шилжих. Тэгээд тэр гэрээнийх нь үнэ дээр нь тэр хөнгөлөлт эдлүүлсэн юм уу эдлүүлээгүй юм уу, эсвэл түрүүний миний яриад байгаа хилийн наана цаана байсан юм уу, байгаагүй юм уу, тээврийн зардал нь шингэсэн юм уу шингээгүй юм уу гэдэг асуудлууд үүсэх гээд байгаа юм. Тэгэхээр энийг яаж ер нь яг тогтоох гээд байгаа юм? Тэгээд наад нэг экспортолсон гэдэг чинь яах вэ шууд гадагшаа гаргачих гэсэн хил давсан гэсэн гэдэг тийм логик шиг шатаад байгаа юм. ашигласан гэдэг нь зөвхөн дотоодод гээд байгаа юм. Тэр хүн гадаадад ашигласан бол экспортолсныхоо үнэд ороод явчих юм уу? Худалдсан гэдэг нь зөвхөн дотоодод гэж яриад байгаа юм. Тэгээд ийм нэг логик хоорондын зөрүү асуудлууд байгаад байна гэж хараад байгаа юм. Энэ дээр яг ямар тайлбар өгөх вэ?

Хэн хариулах юм? Тэлмүүн 7 номер, Сангийн яам.

Г.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн. Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

20-ийн Штрихтэй холбоотой энэ зүйлийг бол бид яг өнгөрсөн хугацааны Оюу Толгой дээр болон бусад компаниуд дээр гардаг сургамжид үндэслээд нэлээн боловсронгуй байдлаар оруулсан байгаа. Яг таны асууж байгаа энэ 20¹.2 дээрх заалт бол ерөнхийдөө яах вэ. Бид Ашигт малтмалын хуулийн үндсэн зарчим томъёолол юуг ингээд үндэслэсэн. Яагаад экспортолсон, өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан гэж байгаа юм гэхээр ер нь бол одоогийн байгаа төслөөр хэлэлцээрийн явцад бол бүх бүтээгдэхүүн экспортлогдоно гэж байгаа юм. Тэгэхдээ тодорхой хэмжээнд туршилтын журмаар ч юм уу өөрийн хэрэгцээнд ашиглагдах эсвэл цөмийн энергийн хуулиар блд экспорт импортын тусгай зөвшөөрөл нь тусдаа ингээд олгогддог. Тэгэхээр ирээдүйд энэ Рона компани Бадрах Энержи гэдэг компани яг борлуулалтынх нь тусдаа компани орж ирээд ингээд хийх ийм боломжууд бол ингээд хуулийн хүрээнд нээлттэй юм байна лээ. Тэгэхээр бид бүх төрлийн экспортолсон байна уу, өөрөө ашигласан байна уу, дотоодод зарсан байна уу ерөөсөө олон улсын зах зээлийн үнээр л авна. Та сайн мэдэж байгаа байх ашигт малтмалын хуулийн 47.2.3-д байдаг олон улсын үнийг тогтоох боломжгүй бол гэрээний үнийг ашиглана гэдэг ийм заалт байдаг. Тэгэхээр энэ заалтыг бол бид нар хэргээр Цөмийн энергийн хуульд оруулаагүй.

Тэгэхээр ямар ч тохиолдолд гэрээний үнэ гэдэг зүйлийг ураны бүтээгдэхүүнд авч явахгүй ээ. Үнэ яаж тогтоодог юм яаж авах юм гэдэг нь бол ер нь яг бид нарын явж байгаа зэстэй адилхан явна. Ураны үнийг зарладаг бирж олон улсын эх сурвалжууд ингээд харьцангуй цөөхөн байдаг. Тэгэхдээ энэ дээр хэд хэдэн эх сурвалжууд л байдаг юм байна лээ. Энэ дээр яг хамгийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тэр эцсийн ураны үнийг зарладаг эх сурвалжийг Засгийн

газар тухайн үед яг одоогийн биржийн үнээр зарладаг энэ зарчмынхаа дагуу зарлаад явна. Эндээс ямар нэгэн байдлаар тээврийн, дундын тэр зардал шилжүүлэг энэ асуудлыг бид нар хасахгүй. Яг Оюу Толгой бусад Эрдэнэт дээр байдаг энэ олон улсын зах зээлийн эцсийн үнээр АМНАТ-аа бодож авна. Энэ дээр яах вэ ажлын хэсгийн хүрээнд илүү тодорхой зүйл болох зүйл байвал бид нар оруулаад явахад бүрэн боломжтой байх.

Тэгэхээр бид нар илүү нарийвчилж гардаг одоо энэ АМНАТ-тай холбоотой маргаан гарахгүй байдлаар бол тусгасан. Мөн урьдчилсан байдлаар хэлэлцээрийн явцад бол АМНАТ-тай холбоотой асуудлыг бид ийм байдлаар хатуу байр суурь илэрхийлж байгаа. Аль энэ талаас бол АМНАТ дээр энэ тээврийн зардалтай холбоотой асуудлыг анх тавьж байсан. Одоо бол энэ асуудлыг бол харьцангуй тавихгүй. Бид нар яг Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ тэр эцсийн Лондоны металлын бирж гэдэг шиг энэ зарчмаар авна гэдэг хатуу байр суурь илэрхийлж байгаа. Энэ дээр ямар нэгэн юу бол гарах гэдэг ийм байр суурьтай байгаа.

Г.Тэмүүлэн: Би тодруулаад асуугаадахъя. Сая та бүхний томъёолоод биччихсэн байгаа экспортолсон гэж байгаа таслал гээд. Тэгэхээр энэ экспортолх этгээд чинь тусгай зөвшөөрөл эзэмших юм уу? Би зүгээр асуугаад байгаа логик нь бол тэр дотоодод борлуулсан бөгөөд цааш нь экспортолсон этгээд хоорондын нөгөө нэг татварын уялдааг нь хангаж өгөхгүй бол дахиад наадах чинь нэг логик дараалал алдаа гараад байдаг. Эсвэл наадах чинь дотоодод худалдан авч байгаа этгээд экспортолхгүй гэсэн үг үү, боломжгүй гэсэн үг үү гэдэг ч юм уу иймэрхүү татварын тэр уялдааны зөрөөнүүд гарч ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр ерөөсөө нэг мөр жигдлээд хэн ч маргаангүйгээр татварын маргаан үүсгэхгүй байх асуудлыг хийхгүй бол танай дээр ч гэсэн өмнөх бусад боловсруулсан үйлдвэр одоо юутай холбоотой давхар АМНАТ-ын

асуудлууд маш их яригддаг. Тэгээд нөгөө давхар давхар АМНАТ төлчхөөд буцаагаад нөгөөдхөө авъя гэхээр авч чаддаггүй ийм хийдэл цоорхойнууд бол байгааг байдаг. 7 номер.

Г.Тэлмүүн: Тэмүүлэн гишүүний асуултад нэмж хариулъя.

Цөмийн энергийн хуулиар бол 15.1 дээр ашиглах тусгай зөвшөөрөл 15.1.2, 15.1.4 дээр импортлох, экспортлох гээд ингээд тусгай зөвшөөрлүүд нь тусдаа. 15.2-т зааснаар ингээд тусдаа явж байгаа. Бид яг таны хэлж байгаа логик бол Ашигт малтмалын хуулиар дотоодод борлуулах юм бол олон улсын зах зээлийн үнийг авахгүй гэрээний үнийг авдаг ийм Ашигт малтмалын хуулийн зохицуулалттай. Энэнээс болоод нөгөө давхар АМНАТ дотоод гадаадын үнэ гэдэг зөрүү гараад нөгөө асуудал яригддаг. Бид оруулж байгаа хувилбар бол дотоодод зарна уу, экспортолно уу, өөрөө ашиглана уу, ерөөсөө шууд л олон улсын зах зээлийн үнээрээ авна гэдэг энэ хатуу зарчим барьж орж ирж байгаа юм. Илүү сайжруулж байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ дээр ямар нэгэн зөрүү гарахгүй.

Яг наадахтай дахиад нэг сүүлийн тодруулга ингээд асуугаадахъя. Яг хэн олборлоод, хэн дотоодод худалдан аваад, хэн экспортолх вэ гээд яг энэ бүх шатууд дээр нөгөө тусгай зөвшөөрөл олгох уу? Энэ чинь тус тусдаа харилцаанууд шүү дээ. Хэн хариулах юм? Нэг номер юм уу, 8 номер юм уу? 8 номер.

Г.Намчинсүрэн: Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яам Намчинсүрэн. Тэмүүлэн гишүүний асуултад нэмж хариулъя аа. Ерөнхийдөө бол цацраг идэвхт ашигт малтмал эрэх хайх, ашиглах асуудлыг бол геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрлийг нь олгох бол хуультай байгаа. Мөн дээрээс нь сая Тэлмүүн дарга хэлж байна. Цацраг

идэвхт ашигт малтмал, импортлох экспортлох, тээвэрлэх, хаяглалыг буулах болон цацраг идэвхт ашигт малтмалыг ашигласны дараа нөхөн сэргээх асуудлыг бол тусгай зөвшөөрөлтэйгөөр хийнэ гээд Цөмийн энергийн хуулийн 15.2-т заачихсан байгаа.

Г.Тэмүүлэн: Ойлголоо.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Асуулт асууж, хариулт авч дууслаа. Батбаатар гишүүнээр тасалъя үг хэлэх гишүүдийг. Ганбат гишүүнээр. Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна аа. Тэгээд олон нийтдээ маш тодорхой оновчтой зөв хэлбэрээр мэдээллүүдээ өгөөд энэ Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнээс хойш хийгдэж байгаа томоохон энэ хөрөнгө оруулалтын гэрээний ажлууд ингээд урагшлуулах зүй ёсны шаардлага Монгол Улсад байна гэдэг зүйлийг хэлмээр байна. Энэ хууль хэлэлцэх, энэ гэрээ хэлэлцээрүүд явахтай зэрэгцээд нөгөө шантааждын арми чинь амилна аа. Энүүнд нэг автмааргүй байна. Монгол Улс нэг шийдвэрээ гаргаж сурмаар байна. Шийдвэр гаргахгүй байсаар байтал Монгол Улсын зөв буруугаа ч ерөөсөө тодорхой салбаруудад мэдэж чадахгүй байна шүү дээ. Тухайн асуудал байсаар л байдаг ярьсаар л байдаг. Тэгэхээр энэ дээрээ бас нэг гишүүд маань дэмжих байх. Би тэгээд Засгийн газар ялангуяа Учрал сайдыг яг энийг олон нийтийн эргэлзэж байгаа тэр зүйлүүд дээр мэдээллийг маш оновчтой зөв өгөөрэй л гэж хүсэж байна. Мэдээллийн өгөөгүйгээсээ болоод одоо нөгөө янз янзын 3, 4 нүдтэй хурга, ишиг, тугал ярьсаар байгаад ерөөсөө энэ том эдийн засгийн энэ төслүүдийг зогсоодог энэ бүх зүйлүүд рүү явлаа.

Дээрээс нь мэдээж энэ хуулийн агуулга энэ тэрийг сайжруулаад ярих юм байж болох байх. Ер нь зүгээр цаашидаа

хэлэлцээрийг Монгол Улс ямар нэгэн байдлаар санхүүгийн эрсдэл үүрэггүйгээр 34 хувийг эзэмшихгүйгээр тодорхой хэмжээний давуу эрх болон алтан хувьцаа эзэмшээд тодорхой шийдвэрүүд дээр бето эрхээ тавиад энэ ингээд одоо бас нэг хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг хийж үр өгөөжөө хүртмээр байна аа. Томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх гэж байгаа энэ үе дээр ерөнхийдөө Монгол Улс дахиад хөрөнгөмйэ 34 хувийг эзэмшиж хөрөнгө оруулалт хийнэ гэдэг их хэцүү. Тэгэхээр энийгээ бодолцоод хаа хаанаа автахгүйгээр санхүүгийн модель дээрээ зөв ажиллаад энэ төслийг урагшлуулахад зүтгээд яваасай л гэж хүсэж байна.

Тэгээд хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна аа.

Г.Тэмүүлэн: Батбаатар гишүүн үг хэлье.

Б.Батбаатар: Бид нар аливаа асуудлаас тойрч зугтах юм уу холдож өгөхгүйгээр нүүр тулаад бариад авах ёстой. Тэгж байж бид нар улс орны асуудлуудыг шийддэг, тулгарч байгаа сайн муу бүх зүйлийн ард гарч чаддаг байх ёстой. Тэгээд энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад цацраг идэвхт хаягдал, цөмийн түлшний 7 асуудал байгаагаас энэ дээр нэг зөвлөмж санал хэлбэрээр хэдэн зүйл хэлье ээ.

Энэ нэг дэх асуудал дээр нь Монгол Улсын байгаль орчин, нийгмийн эрүүл мэндийн эрх ашгийг хамгаалах үүднээс гадаадын цацраг идэвхт хог хаягдлыг импортлох, дамжин өнгөрүүлэх, буулахыг хатуу хориглохыг дэмжиж байгаа энэ заалтыг дэмжиж байна. Гэсэн хэдий ч бид нар энд үүндээ хэрэгжилтийн механизмыг нь тодорхой зааж өгсөн байх, үүндээ хатуу хяналт тавих зөрчил гарсан тохиолдолд хариуцлагыг хэрхэн тооцож арга хэмжээ авах юм бэ гэдгээ нарийвчлах ийм зөвлөмж гаргаж байна. Саналын хувьд бол бид нар хог хаягдлыг нэвтрэх цэгүүдэд илрүүлэх, зохицуулах, тодорхой протоколуудыг мэргэжлийн

хяналтын байгууллага болон эсвэл ОУБ-тай түншилэх замаар бий болгох чиглэлд ажиллах шаардлага байна. Төрийн өмчийн хувьцааг тусгай нөөц ашигласны төлбөр болон бусад сонголтоор орлуулах гэж байгаа дээр төрийн өмчийн хувьцааг тусгай роялти буюу өөр хувилбараар орлуулах нь уян хатан байдлыг бий болгож болох ч энэ нь төрийн стратегийн ашиг сонирхлыг алдагдуулж урт хугацааны орлогын эх үүсвэрийг бууруулахгүй байх ёстой гэж үзэж байна. Зөвлөмжийн тухайд өмчлөлийг хэзээ яагаад нөөц ашигласны төлбөр эсвэл бүтээгдэхүүн хуваах загвараар солихыг үнэлэхийн тулд бид нар ил тод үнэлгээний системийг нэвтрүүлэх хэрэгтэй. Хариуцлага тооцох зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэхийн тулд аливаа шийдвэрийг олон нийтэд тогтмол нээлттэй мэдээлдэг байх энэ загварыг бий болгох хэрэгтэй.

Гуравт нь уурхайн хаалт, нөхөн сэргээлт, засвар үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн журам гээд энэ төсөл дээр явж байна. Байгаль орчныг нөхөн сэргээх санхүүгийн хариуцлагыг баталгаажуулж байхын тулд тэр хаалтын дараах үйл ажиллагаанд зориулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчид хөрөнгө байршуулах шаардлагыг дэмжинэ гэж. Оруулж ирж байгааг дэмжиж байна. Зэрэгцээ санал нь юу вэ гэхээр санал болгож буй хөрөнгийг зориулалтын бусаар ашиглагдахгүй байх тал дээр нь хяналт тавьж аудит хийдэг Засгийн газрын энэ хангалттай байдлыг нь хангахын тулд санхүүгийн хамгийн бага стандартыг тогтоох ёстой гэдэг талаар санал гаргаж байна.

Дөрөвт нь хөрөнгө оруулалтын гэрээг 10 жилээс 20 жил болгож сунгая гэж байгаа. Тэр хөрөнгө оруулалтын гэрээг сунгах нь тогтвортой байдлыг хангах замаар хөрөнгө оруулагчдаа татах боломжтой хэдий ч хуульд нийцүүлэн хангах эдийн засаг, байгаль орчны өөрчлөлтөд дасан зохицох үүднээс урт хугацаанд хяналт тавих механизмыг

тусгах ёстой. Гүйцэтгэл дагаж мөрдөх байдал зах зээл эсвэл хүрээлэн буй орчны нөхцөл байдлын өөрчлөлтийг үнэлэхийн тулд 10 жилийн интервалтайгаар хянан шалгах заалтыг 20 жил болгож байгаа боловч тодорхой хугацаатай ийм интервалтай хяналт шалгалтын нөхцөлүүдийг бий болгож заах нь зүйтэй гэж үзэж байна. Цацраг идэвхт АМНАТ-ын нөөц ашигласны төлбөрийг борлуулалтын үнийн дүнгийн 5 хувиар гээд хүлээлт үүсгэж болох ч гэсэн энэ нь үнийн хэлбэлзлийг харгалзан нэг хувь хэмжээний эдийн засгийн хэлбэлзлийнхээ үр дүнд тэр барьж чадахгүй байж магадгүй юм гэдэг дээр анхаарах хэрэгтэй. Зах зээлийн нөхцөлд инфляцад бага зэрэг тохируулдаг суурь хүүтэй роялти төлбөрийн уян хатан загварыг л санал болгоё.

Монгол Улсын орлогыг эдийн засгийн өөрчлөлтөөс л шалтгаалаад ханиийн уналтаас хамгаалахын зэрэгцээ хөрөнгө оруулагчдын нөхцөлийг урьдчилан таамаглах боломжтой болгоно.

Г.Тэмүүлэн: Дуусгахихъя нэг минут нэмээд өгчихье.

Б.Батбаатар: Шаталсан юун дээр болохоор зах зээлийн үнийн өсөлтөд суурилсан нөөц ашигласныхаа төлбөрийн шаталсан тогтолцоо нь боломжийн арга боловч энэ нь үнийн өсөлтийн үед нэмэлт ашгийн шударга хуваарилалтыг яаж тусгах вэ гэдэг дээр нь эргэн харах хэрэгтэй болж байна. Санал болгож байгаа 0-ээс 130 амдоллар хүртэлх 0-9 хувийн хүүгийн өсөлтөд мэдрэмжийн шинжилгээ хийж байх шаардлагатай байна.

Үнийн өсөлтөөс олох орлогыг хөрөнгө оруулалтыг дэмжихгүйгээр нэмэгдүүлэхийн тулд зах зээлийн үнэлгээнд үндэслэн эдгээр хувь хэмжээг үе үе тохируулдаг тэр зохицуулалтыг хэрхэн оруулах вэ гэдгийг санал болгож байна.

Долоод нь эдийн засгийн үр ашиг ордын шинж чанарт суурилсан төрийн өмчийн уян хатан байдлаа бид нар хэрхэн ишийдэх хэрэгтэй вэ гэдэг дээр эдийн засгийн нөхцөл ордын шинж чанарт тулгуурлан төрийн эзэмшлийн уян хатан хэвийн хэмжээг тогтоох нь зүйтэй. Учрал сайд энэ гишүүдийн саналыг сайн сонсож тэмдэглэж бичиж авч байгаа биз.

Анар гишүүн саналаа хэлье.

Ч.Анар: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүний хувиар энэ хуулийн өөрчлөлт шинэчилсэн найруулга бол зайлшгүй явах ёстой гэж үзэж байна. Бид нар бол алдагдсан боломж өндөр өө. Тэгэхээр энэ төслийг цаашаагаа явуулахад энэ бол ганц уранаа биш цаашилаад ураны нөөц нэлээн баялаг байгаа. Тэгэхээр энэ дээр ганцхан л асуудал яриад байгаа юм. Гаднын хөрөнгө оруулалтаа хаасан хуулийн төсөл боловсруулчхаад хэлэлцээр хийхийг шахаад байх вий дээ. Тэгэхээр улс төржилгүйгээр энэ хууль дээрээ сайжруулалтаа хийгээд энэ төслийг цаашаагаа явуулахад энэ эдийн засгийн хувьд ч тэр, гадаад бодлогын хувьд ч тэр, геополитикийн өнөөгийн нөхцөл байдалд энэ боломжийг алдах ёсгүй л гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Анар гишүүнд баярлалаа. Ганбат гишүүн үг хэлнэ.

Д.Ганбат: Ер нь дэмжиж байна, дэмжих ч ёстой л доо. Эрүүл саруул ухаантай Монгол хүн байдаг л юм бол гэж ойлгож байна. Тэгээд манайхны бид нарын ч гэсэн мэдлэг тун нимгэн байна энэ талаар. Анх удаагаа энэ шинэ юманд бид нар орох гэж байна. Хамт эхлээд явж байсан казахстан гэхэд бол өдийд бараг л эхний нэг, хоёрт орохоор тоглогч болчихсон АЦС-аа барья гэхчхэн. Иргэдээсээ асууж байна л даа. Ер нь л ардчилалтай л улс орон болчихсон байна шүү дээ. Уг нь бид нар урьд нь явж байсан юм. Одоо бид нар Казахстанас л сурах

ёстой болчихоод байна. Тэгээд олон ажлын хэсэг олон сайд нар ахалж ажилласан. 27 жил болж байна. Ямар ч байсан Учрал сайдыг энэ асуудлыг барьж байгаа ажлын хэсгээ ахлаад энэ бүтээгдэхүүнээ гаргаад Монгол Улс руу мөнгө төгрөг нь орж ирээд ард иргэдийн амьдралд бас хэрэгтэй болоод энэ ажлыг бас нэг өөрийнхөө үед дуусгачхаасай гэж бодож байна. Ер нь энэ ажлыг хийчих боломжтой хүнээ таныг ч болов уу гэж харж байна.

Тийм бусдыг нь би мэдэхгүй байна, итгэхгүй байна. Тэгж ингэж байгаад л орхичихдог. Хэл амнаас айдаггүй яадаггүй манайхан очоод л тэгээд л бид нар чинь Франц гэдэг улс бид нараас бага ч гэсэн хамааралтай болж байна гэдэг чинь уул нь ардчилыг дэмждэг, тэрүүгээрээ бид нар гуравдагч орнуудад сайхан харагддаг байлаа л даа. Одоо бол бүдгэрчихсэн. Одоо энэ их олон манай дарга нар очоод айлчлаад л яваад байгаа. Энэ бүхэн бас урантай холбоотой байх аа. Энэ юмаа бид нар тэгээд бас энэ хариулж байгаа юм зүйлүүдийг хараад байхад бол манай хүмүүс болох ч юу байна шүү. Биржээр жирийн арилжаалдаг зүйл мөн юм уу биш юм уу? Энэ Тэмүүлэн даргын асууж байгаа асуултад энэ хариулж чадахгүй л байна шүү дээ. Тусгай бүтээгдэхүүн юм уу энэ тэр гээд. Энэ талаар та бүхэн сайн уншиж судлаарай Ажлын хэсэг сайн ажиллаарай.

Нөгөө талаар та ингээд хариулж байгааг хараад байхад бол энэ төсвийн дундуур нэг их яаралтай ороод ирэх юм биш л байна шүү дээ. Яг өнөө маргаашигүй цаанаа ямар нууц юм байдаг юм, хэлэхгүй, барихгүй юм байдаг юм болов уу? Зүгээр надад хариулж байгааг нь харахад бол тийм яаралтай өнөө маргаашигүй орж ирээд ингэчих тийм горимоор хэлэлцээд байх ийм асуудал биш байна гэж бодож байна шүү.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа.

Та нар маань энэ гишүүдийн хэлсэн саналууд дээр анхаарч ажиллаарай. Хэд хэдэн гол онцлох асуудлууд байна. Давхцаж хэлж байгаа саналууд байна. Хөрөнгө оруулалтын орчин нөхцөлтэй холбоотой хаалтын зардал, тэр Төрийн банканд заавал байршуулах ёстой юу үгүй юу, борлуулалтын үнэлгээ, АМНАТ-д нар гээд саяын тэр АМНАТ-тай холбоотой тэр томъёолол ч гэсэн нэлээн болхидуу байдалтай байна. 34.3 дээр жишээ нь та хэд маань хараарай. Энэ адаглаад энэ 34.4.1 дээр комисс магадгүй хүлээж авах ёстой ч гэдэг юм уу хаалтын төлөвлөгөөг батлах ёстой, хянах ёстой байх байтал магадгүй зөвхөн нэг хүн, нэг хувь хүн байцаагч ч гэдэг юм уу ийм томъёоллын асуудлууд байх шиг байна. Тэгээд энэ болгон дээр бол анхаарч ажиллаарай гэдгийг бол Засгийн газрт хэлэх байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулна.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бүрийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна аа.

Ингээд тус бүрээр нь санал явуулах юм байна.

Нэгдүгээрт, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал, хураалт явуулна аа.

Санал хураалт явуулъя.

Саяын хэлсэн томъёоллоор дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

13 гишүүн дэмжиж 72.2 хувиар дэмжигдлээ.

2.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна аа.

Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалт.

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжинэ.

72.2 хувиар дэмжигдлээ.

3.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

Батсүмбэрэл гишүүн дэмжсэн байна.

Санал хураалтад 18-аас 13 гишүүн дэмжиж 72.2 хувиар дэмжигдлээ.

4.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

72.2 хувиар дэмжигдлээ.

Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы хуралдаанд танилцуулахаар байгаа танилцуулах гишүүн байна уу? Батсүмбэрэл гишүүн хуралдаанд танилцуулна аа.

Ингээд хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан байна. Ажлын хэсэг болон гишүүдэд баярлалаа. Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. баярлалаа.

15.41 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС УРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*